6. Ажлын тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага

6.1 Ерөнхий шаардлага

a) Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгсэл нь үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэлийг багасгах, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ёстой.

b) Ажилтанд хамгаалах хэрэгслийн тодорхой төрлийг сонгохдоо тухайн үйл ажиллагааны болон ажлын аюулгүй байдлын шаардлагуудыг харгалзан үзэж сонголт хийнэ.

c) Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгслийг ажлын аюулгүй байдал нь тоног төхөөрөмжийн хийцээр, үйлдвэрлэлийн процессын зохион байгуулалтаар, архитектур-төлөвлөлтийн шийдлүүдээр болон хамтын хамгаалах хэрэгслээр хангагдах боломжгүй тохиолдлуудад ашиглана.

d) Хамгаалах хэрэгсэл нь техникийн гоо зүйн болон эрүүл ахуй, эргонимикийн шаардлагуудыг хангасан, ажилтаны биеийн хэлбэр, хэмжээнд таарсан хийцтэй байна. Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгслийн өмсгөл хэмжээний ангилал нь компаний ажилтнуудын биеийн хэмжээг аль болох бүрэн багтаасан байна.

e) Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгсэл нь:
   - үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн шалтгаан, эх үүсвэр болохгүй
   - хүний эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэхгүй,
   - хүний биед хүрэлцэх хэсгүүд арьсанд аливаа цочроо, шархлаа үүсгэх хурц ирмэггүй, хатуу ширүүн гадаргуугүй,
   - хүний биеийн цусны эргэлт, амьсгал боогдуулахгүй, хөдөлгөөнд саад учруулахгүй,
   - хэтэрхий том эсвэл хүнд биш,
   - угаалга, химийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн явцад үндсэн шинж чанарууд нь өөрчлөгдөхгүй байх ёстой.

f) Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгслийн тэмдэглэгээ, тусгай тэмдэглэгээ нь MNS ISO 13688:2000 стандартын болон тодорхой нэр төрлийн хэрэгслийн тэмдэглэгээний шаардлагуудыг хангасан байна.

g) Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгсэл нь зориулалт, эдэлгээний хугацааг заасан, ашиглах, арчлах, хадгалах заавартай байна.

h) Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгслийн хамгаалах, физиологи-эрүүл ахуйн болон эдэлгээний үзүүлэлтүүдийн үнэлгээ хийгдсэн байна.

i) Тусгай хувцас, толгой хөл хамгаалах хэрэгслийг хүрээлэн буй орчинд хор нөлөөгүйгээр устгана.

6.2 Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгслийн ангилал, эдэлгээний норм

6.2.1 Энэхүү стандартад заагдаж буй ажлын хувцас, хэрэгслийг дараах байдлаар ангилна. Үүнд:
Ажиллаж буй алба нэгжээс нь хамааруулан:

1. Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газар (АХЗҮГ)-ын ажилтны ажлын тусгай хувцас, хэрэгсэл;
2. Газрын үйл ажиллагааны ерөнхий менежерийн харъяа хэлтэс, нэгжийн (ГҮАЕМХХН)-ийн ажилтны ажлын тусгай хувцас, хэрэгсэл;
3. Бусад хэлтэс, нэгжийн ажилтны (БХН) ажлын тусгай хувцас, хэрэгсэл.

6.2.2 “МИАТ” ТӨХК-ийн ажилтны ажлын тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгслийн нэр төрлийг нэгжээс нь хамааруулан 6.1, 6.2, 6.3-р хүснэгтэд үзүүлэв.

6.1-р хүснэгт

Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын ажилтны ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл

д/д	Зориулалт	Хувцас, хамгаалах хэрэгслийн нэр төрөл	
		Дулааны улирлын	**Хүйтний улирлын**
1	Толгой хамгаалах хэрэгсэл	- Саравчтай малгай	- Өвлийн малгай /ушанка/
2	Гар хамгаалах хэрэгсэл	- Ажлын бээлий	- Дулаалгатай ажлын бээлий
		- Брезентэн бээлий - Резинэн бээлий	
3	Тусгай хувцас	- Зуны хүрэм, өмд (эр, эм) - Борооны цув - Хавар, намрын хүрэм (эр, эм)	- Өвлийн хүрэм, мөрөвчтэй өмд

		- Дохиоллын хантааз (гэрэл ойлгогчтой) - Хамгаалалтын хувцас - Хайлсан металлын шүршдэс, очноос хамгаалах тусгай зориулалтын хувцас - Даавуун хормогч - Резинэн хормогч - Халад - Цагаан халад, өмдний хослол	
4	Хөл хамгаалах хэрэгсэл	- Ажлын гутал (хагас түрийтэй, хамгаалалттай)	- Ажлын гутал (урт түрийтэй, хамгаалалттай)
		- Усны гутал	
5	Бусад хамгаалах хэрэгсэл	- Амьсгал хамгаалах хэрэгсэл	- Амны хаалт /маск - Хошуувч
		- Нүд хамгаалах хэрэгсэл	- Нүдний шил
		- Сонсгол хамгаалах хэрэгсэл	- Чихэвч - Чихний бөглөөс
		- Толгой, нүүр хамгаалах хэрэгсэл	- Малгай / каск - Гагнуурын баг
		- Бусад	- Гар чийдэн - Өндрийн бүс - Зөөврийн газардуулга - Аваарын гэрэлтүүлэг

6.2-р хүснэгт

Газрын үйл ажиллагааны ерөнхий менежерийн харьяа хэлтэс, нэгжийн (ГҮАЕМХХН)-ийн ажилтны ажлын тусгай хувцас, хэрэгсэл

д/д	**Зориулалт**	**Хувцас, хамгаалах хэрэгслийн нэр төрөл**	
		Дулааны улирлын	**Хүйтний улирлын**
1	Толгой хамгаалах хэрэгсэл	- Саравчтай малгай	- Саравчтай дотортой өвлийн малгай
2	Гар хамгаалах хэрэгсэл	- Дулаалгагүй ажлын бээлий	- Дулаалгатай ажлын бээлий
		- Резинэн бээлий	
3	Тусгай хувцас	- Зуны хүрэм, өмд (эр, эм) - Борооны цув - Хавар, намрын хүрэм (эр, эм)	- Өвлийн хүрэм, мөрөвчтэй өмд
		- Дохиоллын хантааз (гэрэл ойлгогчтой) - Хамгаалалтын хувцас - Цагаан халад, өмдний хослол	
4	Хөл хамгаалах хэрэгсэл	- Ажлын гутал (хагас түрийтэй, хамгаалалттай)	- Ажлын гутал (урт түрийтэй, хамгаалалттай)
		- Ажлын гутал - Ажлын гутал (зөөлөн ултай) - Усны гутал	
5	Бусад хамгаалах хэрэгсэл	- Амьсгал хамгаалах хэрэгсэл	- Амны хаалт / маск - Хошуувч
		- Нүд хамгаалах хэрэгсэл	- Нүдний шил
		- Сонсгол хамгаалах хэрэгсэл	- Чихэвч - Чихний бөглөөс
		- Толгой, нүүр хамгаалах хэрэгсэл	- Малгай / каск
		- Бусад	- Гар чийдэн - Өндрийн бүс - Зөөврийн газардуулга

6.3-р хүснэгт

Бусад хэлтэс, нэгжийн ажилтны (БХН) ажлын тусгай хувцас, хэрэгсэл

Д/д	Зориулалт	Хувцас, хамгаалах хэрэгслийн нэр төрөл	
		Дулааны улирлын	**Хүйтний улирлын**
1	Толгой хамгаалах хэрэгсэл	- Саравчтай малгай	- Өвлийн малгай /ушанка/
2	Гар хамгаалах хэрэгсэл	- Дулаалгагүй ажлын бээлий	- Дулаалгатай ажлын бээлий
		- Брезентэн бээлий - Резинэн бээлий	
3	Тусгай хувцас	- Зуны хүрэм, өмд (эр, эм) - Борооны цув - Хавар, намрын хүрэм (эр, эм)	- Өвлийн хүрэм, мөрөвчтэй өмд
		- Дохиоллын хантааз (гэрэл ойлгогчтой) - Хамгаалалтын хувцас - Хайлсан металлын шүршдэс, очноос хамгаалах тусгай зориулалтын хувцас - Резинэн хормогч - Халад - Цагаан халад, өмдний хослол	
4	Хөл хамгаалах хэрэгсэл	- Ажлын гутал (хагас түрийтэй)	- Ажлын гутал (урт түрийтэй)
		- Ажлын гутал (зөөлөн ултай) - Усны гутал	
5	Бусад хамгаалах хэрэгсэл	- Амьсгал хамгаалах хэрэгсэл	- Амны хаалт / маск - Хошуувч
		- Нүд хамгаалах хэрэгсэл	- Нүдний шил
		- Сонсгол хамгаалах хэрэгсэл	- Чихэвч - Чихний бөглөөс
		- Толгой, нүүр хамгаалах хэрэгсэл	- Малгай / каск - Гагнуурын баг
		- Бусад	- Хөндийрүүлэгч резинэн бээлий - Хөндийрүүлэгч резинэн галош (бот) - Хөндийрүүлэгч резинэн хормогч - Хөндийрүүлэгч резинэн дэвсгэр - Гар чийдэн - Өндрийн бүс - Зөөврийн газардуулга - Аваарын гэрэлтүүлэг - Тусгаарлах бариултай ажлын багаж

6.2.3 Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгслийн эдэлгээний нормт хугацаа

“МИАТ” ТӨХК-ийн ажилтны ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэх үед өмсөх зориулалттай ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл бүр эдэлгээний нормт хугацаатай байх ба ажиллагсдын ажлын орчин нөхцөлөөс хамааран нормт хугацаа дараах байдлаар ялгаатай тогтоогдоно (6.4-р хүснэгт).

6.4-р хүснэгт

Ажилтны ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн эдэлгээний нормт хугацаа ба хэмжээ

д/д	Зориулалт	Хувцас, хэрэгслийн нэр төрөл	Эдэлгээний нормт хэмжээ ба хугацаа		
			АХЗҮГ	ГҮАЕМХХН	БХН
1	Толгой хамгаалах хэрэгсэл	Саравчтай малгай	2 жилд 1		
		Саравчтай, дотортой малгай	2 жилд 1		
		Өвлийн малгай	2 жилд 1		
2	Гар хамгаалах хэрэгсэл	Дулаалгагүй ажлын бээлий	Элэгдлийн зэргээр		
		Дулаалгатай ажлын бээлий	Элэгдлийн зэргээр		
		Брезентэн бээлий	Элэгдлийн зэргээр		
		Резинэн бээлий	Элэгдлийн зэргээр		
3	Тусгай хувцас	Зуны хүрэм, өмд (эр, эм)	1 жилд 1	2 жилд 1	
		Борооны цув	2 жилд 1		
		Хавар-намрын хүрэм (эр, эм)	2 жилд 1		
		Өвлийн хүрэм, мөрөвчтэй өмд	2 жилд 1		
		Дохиоллын хантааз (гэрэл цацруулагчтай)	2 жилд 1		
		Хамгаалалтын хувцас	Элэгдлийн зэргээр		
		Хайлсан металлын шүршдэс, очноос хамгаалах тусгай зориулалтын хувцас	Элэгдлийн зэргээр		
		Даавуун хормогч	-	-	2 жилд 1
		Резинэн хормогч	Элэгдлийн зэргээр		
		Халад	2 жилд 1	-	2 жилд 1
		Цагаан халад, өмдний хослол	2 жилд 1		
4	Хөл хамгаалах хэрэгсэл	Ажлын гутал (хагас түрийтэй, хамгаалалттай)	2 жилд 1		
		Ажлын гутал (урт түрийтэй, хамгаалалттай)	2 жилд 1		
		Ажлын гутал	-	-	3 жилд 1
		Ажлын гутал (зөөлөн ултай)	-	2 жилд 1	
		Усны гутал	2 жилд 1		
5	Бусад хамгаалах хэрэглэл	Амны хаалт / маск	Элэгдлийн зэргээр		
		Хошуувч	Элэгдлийн зэргээр		
		Нүдний шил	Элэгдлийн зэргээр		
		Чихэвч / чихний бөглөөс	Элэгдлийн зэргээр		
		Малгай / каск	Элэгдлийн зэргээр		
		Гагнуурын баг	Элэгдлийн зэргээр		
		Хөндийрүүлэгч резинэн бээлий	Элэгдлийн зэргээр		
		Хөндийрүүлэгч резинэн галош (бот)	Элэгдлийн зэргээр		
		Хөндийрүүлэгч резинэн хормогч	Элэгдлийн зэргээр		
		Хөндийрүүлэгч резинэн дэвсгэр	Элэгдлийн зэргээр		
		Гар чийдэн	Элэгдлийн зэргээр		
		Өндрийн бүс	Элэгдлийн зэргээр		

		Зөөврийн газардуулга	Элэгдлийн зэргээр
		Аваарын гэрэлтүүлэг	Элэгдлийн зэргээр
		Тусгаарлах бариултай ажлын багаж	Элэгдлийн зэргээр

Тайлбар: Элэгдлийн зэрэг өндөр буюу их элэгдсэн эсвэл гэмтсэн үед нөхөн хангалт хийнэ.

6.3 Тусгай хувцас, толгой, хөл хамгаалах хэрэгслийн хаяглалт, шошгололт

6.3.1 Хаяглалт, шошгололт

Бүтээгдэхүүн бүр, иж бүрдэл дэх эдлэл бүрийн шошго нь дараах мэдээллийг тусгасан байна:

- бүтээгдэхүүний нэр (загвар, код, артикул),
- үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн улс,
- хамгаалах шинж чанар, хэмжээ (хэрэв байгаа бол),
- үйлдвэрлэсэн огноо эсвэл ашиглалтын хугацаа дуусах огноо,
- ашиглалтын (ISO 3758: 2012) заавар,
- тохирох стандарт, техникийн нөхцөлийн дугаар.
- Өмсгөл хэмжээ, хүйс

6.3.2 Мэдээлэл нь бүтээгдэхүүн дээр шууд, амархан арилахааргүй будгаар бичигдсэн эсвэл зүймэл шошгон дээр, эсвэл сав, баглаа боодол дээр бичигдсэн байна. Мэдээлэл нь амархан уншигдах, хадгалах, тээвэрлэх, борлуулах, эдэлгээний нормт хугацааны турш ашиглах явцад арилахгүй тогтоцтой байна.

6.3.3 Гутлын хаяглалтыг савхи, зориулалтын туузан дээр хэвлэх, хатгаж оёх аргаар хийж, хэл болон түрийний дотор талд тод харагдахуйцаар оёж бэхлэсэн байна.

Барааны тэмдэгийг гутлын дэвсгэр улавч болон гадуур улны ивүүргийн хэсэгт дарна.

6.4 Тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хадгалалт, тээвэрлэлт

6.4.1 Ерөнхий зүйл

a) Үйлдвэрлэгчээс нийлүүлсэн тусгай хувцас, гутал, бусад хамгаалах хэрэгслийг халаалт бүхий, бохирдол, чийгнээс хамгаалсан хуурай агуулахад бусад материал, эд зүйлсээс тусдаа тусгай тавиур, өлгүүрт эсвэл хайрцагт хадгална. Нарны гэрлийн шууд тусгал, цаг агаарын нөлөөллөөс хамгаалагдсан байна. Хамгаалах хэрэгслийг хадгалах зохистой температур нь +15ºC...+25ºC, харьцангуй чийгшил нь 40%-иас 75% байна.
b) Тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг нэр төрөл, өмсгөл хэмжээ, чац болон хамгаалах шинж чанараар нь ангилан ялгасан байх бөгөөд тэдгээрийн дээр бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг заасан хүснэгт өлгөсөн эсвэл хадсан байна.
c) Аваар ослын үед зориулсан тусгай хувцас, гутал нь лац, тамгатай тусгай шүүгээнд эсвэл тусгайлсан байранд хадгалагдана.
d) Алба нэгжүүд нь олгогдсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг хадгалах тусгай хувцасны өрөө, шүүгээтэй байна.

6.4.2 Тусгай хувцсыг тээвэрлэх, хадгалах

a) Бүтээгдэхүүнийг ус, чийг, тоосноос хамгаалж, бүрхүүлтэй буюу тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
b) Хэрэглээний сав баглаа боодолд эвхэж хийсэн, багцалж боосон хувцсыг вандан дээр хадгална. Өлгүүртэй тээвэрлэгдэж ирсэн хувцсыг өлгөж хадгална.
c) Вандангийн хамгийн доод талын тавиур нь шалнаас дээш 0,2 м-ээс багагүй, хананаас бүтээгдэхүүн хүртэл 0,2 м-ээс багагүй, халаалтын хэрэгслээс - 1 м-ээс багагүй зайд, тавиурын эгнээ хооронд 0,7 м-ээс багагүй зайтай байна.
d) Хальсан бүрхүүлтэй даавуун болон резинен материалтай хувцсыг +5ºC...+20 ºC температуртай, агаарын 50%-иас 70%-ийн харьцангуй чийгшилтэй гэрэл багатай өрөөнд халаалтын хэрэгслээс 1 м-ээс багагүй зайд хадгална.

6.4.3 Хөл хамгаалах хэрэгслийг тээвэрлэх, хадгалах

a) Ажлын тусгай гутлыг ус үл нэвтрэх цаасаар доторлосон 50см*80см*75см хэмжээний хайрцагт, эрэгтэй гутлыг 35 хос, эмэгтэй гутлыг 40 хосоор чөлөөтэй хаагдахаар хийж савлан тээвэрлэнэ. Харин зориулалтын чингэлэг хэрэглэвэл хайрцаггүй хадгалж, тээвэрлэж болно.
b) Бэлэн гутлыг үйлдвэрийн байранд, хадгалах агуулахад хайрцаг савгүйгээр задгай хадгалахыг хориглоно.
c) Гутлыг 40%-иас 60%-ийн харьцангуй чийглэгтэй, ердийн температуртай агуулахад, халаалтын хэрэгслээс 1 м-ээс багагүй зайтай, шалнаас 0,3м-0,4 м өндөр вандан дээр хос хосоор нь түрийг нь нугалалгүй хурааж хадгална.
d) Тавиур хоорондын зай 0,7 м-ээс багагүй байна.

e) Резинэн гутлыг +5ºC...+20ºC температуртай, агаарын 50%-иас 70% харьцангуй чийгшилтэй гэрэл багатай өрөөнд, халаалтын хэрэгслээс 1 м-ээс багагүй зайд хадгална.
f) Гутал нь уур, хий болон химийн бодис, нарны шууд тусгалаас хамгаалагдсан байна.

7. Тусгай хувцсанд тавих техникийн шаардлага

7.1 Тусгай хувцас, хэрэгслийн загварууд

7.1.1 Хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалж хувцасны загвар, өнгө, түүнд ашиглах материал нь өөр байна. “МИАТ” ТӨХК-ийн хэмжээнд 7.1-р хүснэгтэд заасан үндсэн нэр төрлийн тусгай хувцас, хамгаалах хэрэгслүүдийг ашиглана.

7.1-р хүснэгт

Тусгай хувцасны загварын дугаар

д/д	Зориулалт	Хувцас, хэрэгслийн нэр төрөл	Загварын дугаар		
			АХЗҮГ	ГҮАЕМХХН	БХН
1	Толгой хамгаалах хэрэгсэл	Саравчтай малгай - зуны	ТХХ-З-01		
		Саравчтай, дотортой малгай - өвлийн	-	ТХХ-Ө-02	-
		Өвлийн малгай - чихтэй	ТХХ-Ө-03	-	ТХХ-Ө-03
2	Гар хамгаалах хэрэгсэл	Дулаалгагүй ажлын бээлий	-	-	-
		Дулаалгатай ажлын бээлий	-	-	-
		Брезентэн бээлий	-	-	-
		Резинэн бээлий	-	-	-
3	Тусгай хувцас	Зуны хүрэм, өмд (эр, эм)	ТХ-З-01	ТХ-З-02	ТХ-З-03
		Борооны цув	ТХ-БЦ-01	ТХ-БЦ-02	ТХ-БЦ-03
		Хавар, намрын хүрэм (эр, эм)	ТХ-ХН-01	ТХ-ХН-02	ТХ-ХН-03
		Өвлийн хүрэм, мөрөвчтэй өмд	ТХ-Ө-01	ТХ-Ө-02	ТХ-Ө-03
		Дохиоллын хантааз (гэрэл ойлгогчтой)	ТХ-ДХ-01		
		Хамгаалалтын хувцас	-	-	-
		Хайлсан металлын шүршдэс, очноос хамгаалах тусгай зориулалтын хувцас	ТХ-Г-01		
		Даавуун хормогч	ТХ-Г-02		
		Резинэн хормогч	ТХ-Г-03		
		Халад	ТХ-Х-01		
		Цагаан халад, өмдний хослол	-	-	-
4	Хөл хамгаалах хэрэгсэл	Ажлын гутал (хагас түрийтэй, хамгаалалттай)	ХХХ-АГХТ-01		
		Ажлын гутал (урт түрийтэй, хамгаалалттай)	ХХХ-АГУТ-02		
		Ажлын гутал	ХХХ-АГ-03		-
		Ажлын гутал (зөөлөн ултай)	ХХХ-АГЗУ-04		
		Усны гутал	-	-	-
5	Бусад хамгаалах хэрэглэл	Амны хаалт / маск	-	-	-
		Хошуувч	-	-	-
		Нүдний шил	-	-	-
		Чихэвч / чихний бөглөөс	-	-	-
		Малгай / каск	-	-	-
		Гагнуурын баг	-	-	-

		Хөндийрүүлэгч резинэн бээлий	-	-	-
		Хөндийрүүлэгч резинэн бот / галош	-	-	-
		Хөндийрүүлэгч резинэн хормогч	-	-	-
		Хөндийрүүлэгч резинэн дэвсгэр	-	-	-
		Гар чийдэн	-	-	-
		Өндрийн бүс	-	-	-
		Зөөврийн газардуулга	-	-	-
		Аваарын гэрэлтүүлэг	-	-	-
		Тусгаарлах бариултай ажлын багаж	-	-	-

7.2 Тусгай хувцсанд тавих техникийн шаардлагууд

7.2.1 Өмсгөл хэмжээ

Тусгай хувцасны өмсгөл хэмжээ нь ажилтны биеийн хэмжээнд таарч байх ёстой. ISO 3635, MNS ISO 13688:2000 стандартын хэв шинжит галбиртай хүний биеийн хэмжээнд үндэслэн МИАТ ТӨХК-ийн ажилтны ажлын хувцасны өмсгөл хэмжээг тодорхойлох бөгөөд дээрх стандартуудад заасны дагуу ажилтнаас биеийн хэмжээг авна.

Хувцасны өмсгөл хэмжээг: биеийн өндөр (чац), цээжний 3-р бүслүүр гэсэн үндсэн хэмжээсүүдээр тодорхойлно.

Шаардлагатай бол нэмэлтээр дүүргэвчийн хэмжээ (бүсэлхийн бүслүүр- эрэгтэй хүнд), өгзөгний бүслүүр- эмэгтэй хүнд), ханцуйны урт ашиглана.

Эрэгтэй ажилтны өвлийн болон зуны улирлын хүрэм, өмд, цув, дохиоллын хантааз, цамц, халадыг таван төрлийн өмсгөл хэмжээтэйгээр тав хуртэл чацтайгаар, эмэгтэй ажилтны өвлийн болон зуны хүрэм, өмд, дохиоллын хантааз, халадыг дөрвөн төрлийн өмсгөл хэмжээтэйгээр дөрвөн өөр чацтайгаар үйлдвэрлэнэ.

МИАТ ТӨХК-ийн ажилтны хувцасны өмсгөл хэмжээ нь 7.2-р хүснэгтэд үзүүлсэн хэв шинжит галбирын чац, цээжний бүслүүрийн хэмжээнд тохирсон байна.

7.2-р хүснэгт

Гадуур хувцасны өмсгөл хэмжээ ба биеийн хэмжээ

Хувцасны өмсгөл хэмжээ	Хэв шинжит галбирын чац,см (интервал 6 см)	Чацын хэмжээний хэлбэлзэл, см	Хэв шинжит галбирын цээжний бүслүүр, см (интервал 4 см)	Цээжний бүслүүрийн хэмжээний хэлбэлзэл, см
Эрэгтэй ажилтан				
44/46	164 170 176 182	161-166,9 167-172,9 173-178,9 179-184,9	88/92	86-93,9
48/50	164 170 176 182 188	161-166,9 167-172,9 173-178,9 179-184,9 185-190,9	96/100	94-101,9
52/54	164 170 176 182 188	161-166,9 167-172,9 173-178,9 179-184,9 185-190,9	104/108	102-109,9
56/58	164 170 176 182	161-166,9 167-172,9 173-178,9 179-184,9	112/116	110-117,9

	188	185-190,9		
60/62	164 170 176 182 188	161-166,9 167-172,9 173-178,9 179-184,9 185-190,9	120/124	118-125,9
Эмэгтэй ажилтан				
42/44	158 164 170 176	155-160,9 161-166,9 167-172,9 173-178,9	84/88	82-89,9
46/48	158 164 170 176	155-160,9 161-166,9 167-172,9 173-178,9	92/96	90-97,9
50/52	158 164 170 176	155-160,9 161-166,9 167-172,9 173-178,9	100/104	98-105,9
54/56	158 164 170 176	155-160,9 161-166,9 167-172,9 173-178,9	104	106-113,9

Хувцасны загварыг зохион бүтээлтийг хүснэгт 7.1, 7.2-д заасан эрэгтэй болон эмэгтэй хүний 3-р дүүргэвчтэй хэв шинжит галбирын биеийн үндсэн хэмжээст тааруулан хийнэ. Дээр дурьдсан өмсгөл хэмжээнээс их эсвэл бага үед хэрэглэгчийн биеийн хэмжээний онцлогт тохируулан захиалгаар үйлдвэрлэнэ.
Ажилтны биеийн өмсгөл хэмжээг тодорхойлоход А1 хавсралтын 1-3-р зураг, 1-р хүснэгтэд заасан зөвлөмжийг ашиглана.

7.2.2 Техникийн шаардлагууд

7.2.2.1 Хамгаалах шаардлага

a) Хувцасны хийц нь үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлс хувцасны дотор тал руу үсрэх, урсах, нэвтрэх, нэвчихээс дээд зэргээр хамгаалсан байна.
b) Хувцсыг дуулга малгай (каск), бээлий болон бусад шаардлагатай зүйлийн хамт иж бүрнээр нь өмсөж ашиглана. Дуулга малгай нь толгой, үс, нүүр хүзүүний арьсыг хамгаалах ёстой. Малгай нь ажиллах үед толгойгоо эргүүлж, тонгойж гэдийхэд саад болохооргүй хийцтэй байна. Бээлий нь гарыг бүрэн хамгаалах, бээлийний дотор тал руу орохоос хамгаалах хийцтэй байна.
c) Хувцасны хамгаалах чадварыг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлсээс хамгаалах шинж чанартай материалаар давхарлагууд хийж өгнө. Хамгаалах давхарлагуудын байрлал, хэлбэр нь хөдөлмөрийн нөхцөлөөс хамаарч, үйлдвэрлэлийн аюултай хортой хүчин зүйлийн шинж чанараар тодорхойлогдоно.
d) Хувцасны гадаргуу нь үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлс тогтохооргүй толигор байна.
e) Хувцасны гадаргууд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжтэй ороцолдох, дэгээдэгдэх бүч гэх мэт сул үзүүр байх ёсгүй.
f) Хувцасны өнгө нь үйлдвэрлэлийн байрны интерьер, гэрэлтүүлэгт зохицсон, машин тоног төхөөрөмжөөс ялгарч харагдах өнгөтэй байна. Хувцас нь алсаас болон гэрэл багатай, харанхуй газарт ажилтны байгаа газрыг мэдээлдэг дохиоллын элементтэй байна.
g) Аюул тохиолдсон үед шаардлагатай бол тайлахад хялбар байна.

7.2.2.2 Эргономикийн шаардлага

Тусгай хувцасны загварыг дараах шаардлагуудад нийцүүлэн зохион бүтээнэ. Үүнд:

a) Хувцас нь өмсөх цаг агаарын нөхцөл, улиралд тохирсон байна (зуны, хавар намрын, өвлийн, бүх улирлын).
b) Хувцас нь зохих хамгаалалтын зэрэгцээ хэрэглэгчийн тав тухтай байдлыг дээд зэргээр хангасан байна.

c) Хувцас нь хүний эрүүл мэндэд хортой болон тааламжгүй нөлөө үзүүлэхээргүй хийц, материалтай байна.
d) Хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд арьсанд аливаа цочроо, шархлаа үүсгэх хурц ирмэггүй байна.
e) Хувцасны хийц нь тухайн мэргэжлийн онцлог, хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөнд тохирсон, биед эвтэй, ажлын явцад чөлөөтэй хөдлөх боломжийг хангасан, товчлоос нь өмсөж тайлахад хялбар байна
f) Хувцасны зарим бүрдэл хэсгүүдийн хэмжээг хувь хүний биеийн морфологийн онцлогт тохируулан өөрчилж болохуйц хийцтэй байж болно.
g) Хувцас нь эрүүл ахуйн шаардлага хангасан, чийг шингээлт, агаар нэвтрүүлэлт сайтай, өвлийн хувцас нь хүйтнээс найдвартай хамгаалах хийцтэй байна.
h) Хувцасны хийцэд хувцасны дорхи давхаргын бичил орчны хэвийн байдлыг дэмжих элементүүд оруулж болно: хөлс ихээр ялгардаг хэсгүүдэд салхивчны нүх, онгорхой гэх мэт.
i) Цээжний, бүсэлхийн, өгзөгний бүслүүр дээрх чөлөөт хөдөлгөөний сулын тавилтын хэмжээ нь амьсгалах, цусны эргэлт, хувцасны дорхи давхаргын агаарын хөдөлгөөн, биеийн хөдөлгөөний чөлөөт байдлыг хангаж байх ёстой.
j) Хувцасны жин нь ажиллагчийн организмд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна.
k) Хувцасны дотуур биеэс ялгарах хөлс чийгийг сайн шингээх материалаар хийгдсэн нимгэн цамц өмсөнө.
l) Хөдөлмөрийн багаж хэрэгсэл хийх халаас болон товчлоос, бусад шаардлагатай элементүүд нь оновчтой хэмжээ, байрлал, хийцтэй байна.

7.2.2.3 Эдэлгээний шаардлагууд

a) Хувцас нь бөх бат, нормт хугацааны туршид хамгаалах чадвараа хадгалах, эдэлгээнд найдвартай (хэлбэрээ хадгалалт, элэгдэлт тэсвэрлэлт сайтай), засварлах боломжтой, шаардлагатай тооны угаалга, индүүдлэгийг тэсвэрлэх чадвартай байна.
b) Ашиглалтын явцад хувцасны материал, оёсон оёдол нь урагдахгүй, элэгдэл болон үйлдвэрлэлийн төрөл бүрийн хүчин зүйлийн нөлөөллийг тэсвэрлэх чадвартай байна.

7.2.2.4 Гоо зүйн шаардлага

a) Хувцасны загвар дизайн, өнгөний шийдлүүдийг хэрэглэгчтэй тохирсны үндсэн дээр нь тусгай хувцасны орчин үеийн загварын чиг хандлагад болон хэрэглэгчийн таашаалд нийцүүлэн, хувцасны дизайны зарчмуудыг баримтлан боловсруулсан байна.
b) Компаний хэмжээнд ашиглах тусгай хувцасны загваруудын гадаад байдал нь ""МИАТ" ТӨХК-ийн ажилтнуудын ажлын тусгай зориулалтын хувцасны загвар"-ын альбомд тусгасан техникийн зургуудтай тохирч байна.
c) Хувцасны боловсруулалт, шошго, эмблем нь зохих шаардлага хангасан, гадаад үзэмж чанарын шаардлага хангасан байна.
d) Байгууллагын лого, таних тэмдгийг зуны костюм, хавар, намрын болон өвлийн иж бүрдлийн хүрмэн дээр компьютер хатгамал (утас нь -хатгамлын зориулалттай торгон), эсвэл хэвлэлийн аргаар хийсэн байна.
e) Компаний "Brand book"-д заасны дагуу "MIAT Mongolian airlines" гэсэн үг бүхий логог арын болон энгэрийн бүрдэл хэсэг дээр байрлуулна: 75 мм*250 мм хэмжээтэй логог арын бүрдэл хэсэг дээр, 25 мм*105 мм хэмжээтэй логог энгэр дээр байрлуулна. Малгайн цохны хэсэгт 6,0 см диаметртэй логог голлуулан байрлуулна.

MIAT
MONGOLIAN AIRLINES

1-р зураг. Хувцасны ар, энгэрт болон малгайд байршуулах компаний лого

f) Ажилтнуудын тусгай хувцасны загвар болон өнгө нь харьяалагдах нэгжээс хамаарч ялгаатай байх боловч тэдгээрийн хувцасны өнгөний кодыг 7.3-р хүснэгтэд үзүүлэв.

7.3-р хүснэгт

Ажлын хувцасны өнгөний код

№	Харьяалагдах нэгж, хэлтэс	Хувцасны нэр төрөл	Өнгөний нэршил Монгол, Англи	Pantone систем дэх өнгөний код
1	Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газар (АХЗҮГ)-ын ажилтан	Ажлын хувцасны голлох өнгө	Хар хөх: Night Sky	Pantone 19-3924 TPX
2			Неон шар: Safety Yellow	Pantone 16-0630 TN
3		Цув, хантаазны суурь өнгө	Неон шар: Safety Yellow	Pantone 16-0630 TN
4		Цацруулагч	Саарал: Frost Gray	Pantone 17-0000 TPX
5	Газрын үйл ажиллагааны ерөнхий менежерийн харьяа хэлтэс, нэгжийн (ГҮАЕМХХН) ажилтан	Ажлын хувцасны голлох өнгө	Хөх: Medieval Blue	Pantone 19-3933 TPX
6			Шар ногоон: Lime Punch	Pantone 13-0550 TPX
7		Цув, хантаазны суурь өнгө	Неон шар: Safety Yellow	Pantone 16-0630 TN
8		Цацруулагч	Саарал: Frost Gray	Pantone 17-0000 TPX
9	Бусад хэлтэс, нэгжийн (БХН) ажилтан	Ажлын хувцасны голлох өнгө	Хөх: Blue Depths	Pantone 19-3940 TPX
10			Хар: Tap shoe	Pantone 19-4004 TPX
11			Шар ногоон: Lime Punch	Pantone 13-0550 TPX
12		Хантаазны суурь өнгө	Неон шар: Safety Yellow	Pantone 16-0630 TN
13		Цув	Улбар шар: Zinnia	Pantone 14-1159 TPX
14		Цацруулагч	Саарал: Frost Gray	Pantone 17-0000 TPX
15	Бүх төрлийн гутал		Хар: Tap shoe	Pantone 19-4004 TPX
12	Халад		Цагаан: Bright White	Pantone 11-1601 TPX
13	Лого		Цэнхэр: Hyper Blue	Pantone 2728 C
			Улаан: Red	Pantone 485 C

7.2.2.5 Аюулгүй байдлын шаардлага

a) Тусгай хувцас нь ашиглалтын явцад аюултай, хор хөнөөлтэй хүчин зүйл, ослын шалтгаан болохгүй байна.
b) Тусгай хувцас, дагалдах хэрэгсэл үйлдвэрлэх материал нь ариун цэвэр, эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн тогтоосон стандартад нийцсэн байна.
c) Хувцасны материал нь хүний биед хортой нөлөө үзүүлдэг хортой хольц агуулаагүй байна. Энэхүү шаардлагыг ажлын хувцас үйлдвэрлэхэд ашигласан материалын аюулгүй талаарх шинжилгээний хуудсаар баталгаажуулна.
d) Тусгай хувцсыг дахин боловсруулах арга нь байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй байна.
e) Гэрэл ойлгогч цацруулагч материалаар тусгай зориулалтын хувцсанд ашигладаг дохиоллын элементүүд нь тэдгээрт тавигдах шаардлагад нийцнэ.

7.2.3 Бүтээгдэхүүнд ашиглах материалд тавих шаардлагууд

Тусгай хувцсанд ашигласан материал нь тухайн зориулалтын хувцасны хамгаалах шинж чанарыг хангах үзүүлэлтүүдтэй байна.

Мөн хүний эрүүл мэндэд хортой формальдегид, хүнд металл, фенол, хориглосон будаг, харшил өгдөг будаг агуулаагүй, таагүй үнэргүй, хортой бодис ууршуулдаггүй, pH хэвийн байх нэмэлт шаардлага хангасан байна.

7.2.4 Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд тавих шаардлагууд

a) Хувцсыг энэхүү стандартад дурьдсан шаардлагуудад нийцүүлэн батлагдсан эх загвараар техникийн баримт бичигт заасны дагуу үйлдвэрлэнэ.

b) Хувцсанд хатгац, оёдол хийхэд тавигдах шаардлага:

- Хувцасны хатгац, оёдлын төрөл MNS ISO 4916:2011, MNS ISO 4915:2012 стандартад нийцсэн байна.
- Хувцасны бүх оёдол 1,0 см-т 3-3,5 ширхэг хатгацтай байх ба ил оёдол нь тэгш, алгасаагүй, шигээгүй, тунараагүй, муруйгүй байна.
- Хувцасны нэгтгэх оёдлуудын тасралтын ачаалал 250 Н-аас багагүй байна.
- Хувцасны суга, өмдний суудлын оёдол, халаас, мөрний оёдол гэх мэт ачаалалд их өртдөг зангилаа хэсгүүдийн бат бөх байдлыг хангахын тулд нэгтгэж оёхоос гадна хос ил оёдол хийнэ, мөн гинжин хатгацтай машинаар оёно.
- Хос оёдол хоорондын зай загвараас хамаарах бөгөөд оёдлын бүх уртын туршид ижил зайд зэрэгцээ байрлана.
- Хувцсанд ашиглах үндсэн болон туслах материалын өнгөтэй зохицсон өнгийн, бөх утсаар оёно.

c) Оёдол бүрийн төгсгөлд зайлшгүй бөхөлгөө хийх ба түүнд тавигдах шаардлага нь:

- Ердийн хатгац (MNS ISO 4915:2012) бүхий оёдлын төгсгөлд буцах чиглэлээр 0,7 см-1,0 см урттай бөхөлгөө хийнэ.
- Гинжин хатгац бүхий оёдлын бөхөлгөөг 1,0 см-д ноогдох хатгацын тоог 10 ширхэг хүртэл нэмэгдүүлэх байдлаар эсвэл оёдлын утсыг 0,5см-0,7см урттайгаар үлдээж хийнэ.
- Битүү оёдлын эхлэл төгсгөлийн бөхөлгөөг оёдлын мөрөн дээр 1,0 см-2,0 см урттайгаар давхарлаж хийнэ.
- Бүх хувцасны халаасны таг, хагалбар болон оёдолд орсон ташуу халаасны эхлэл, төгсгөл, ил халаасны амсар, далд товчлоос, оноо, хагалбар, цахилгаантай болон товчтой өмдний халаа, бүсний сойлт, саалт, түдүүлд тусгай зориулалтын машинаар бөхөлгөө хийнэ.
- Товч, цахилгаан товч хадах, товчны нүх гаргахад тавигдах шаардлага:
  - Товчны нүхний уртын хэмжээ уг бүтээгдэхүүнд хадагдах товчны диаметрээс 0,2 см-0,5 см илүү байна.
  - Товч хадах, товчны нүх гаргахдаа хоёроос доошгүй давхарласан материал дээр хийж гүйцэтгэнэ.
  - Товчны нүхийг заавал тусгай зориулалтын машинаар гаргаж, цоолсон байх ба төгсгөлийг бөхөлсөн байна.
  - Товчийг түүнтэй ижил өнгийн утсаар хадна.
  - Товчлоосны зориулалттай товчийг зориулалтын машинаар хадна.
  - Машинаар хадах үед: товч болгоныг 12-оос доошгүй хатгацаар оёно.
- Бүтээгдэхүүний ил харагдах бүх зах ирмэгүүдийг боловсруулсан (хэрэх, эмжих г.м) байна.

7.2.5 Хувцасны шошгонд тавих шаардлага

a) Хувцас бүр үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн улс, тухайн хувцасны өмсгөл хэмжээ, өмсөх хүний биеийн хэмжээ (биеийн өндөр, цээжний тойрог), материалын ширхэгтийн холио, ашиглалтын заавар (ISO 3758: 2012) мэдээлэл бүхий шошготой байна.

b) Шошго нь сайн харагдах, элэгдэл багатай газар байрлах ба уншигдах боломжтой, гаргацтай байна.

Жич: гадуур хувцасны шошгыг арын дотрын голд хоолойн ухлаадасны шугамнаас доош, өмсгөл хэмжээ, өмсөх хүний биеийн хэмжээ, материалын ширхэгтийн холио, угаалга ашиглалтын заавар мэдээлэл бүхий шошгыг дотрын зүүн талын хажуугийн оёдолд хавчуулж оёхыг; дан хувцасны хувьд дотрын халаасны ирмэгээс доош, өмдний хувьд ар бүсний залгаас оёдолд хавчуулж оёхыг зөвлөж байна.

c) Шошго нь тухайн хувцасны заагдсан эдэлгээний хугацаанд угаалга, цэвэрлэгээг (угаалга, цэвэрлэгээний тоонд тохирох) тэсвэрлэхээр бат бөх байна.

d) Шошго нь хүний арьсыг нухаж холгохгүй, харшил өгөхгүй материалаар хийгдсэн байна.

e) Шошго, зурган тэмдэглэгээ (пиктограмм) нь тоон болон тусгай мэдээллийг хурдан уншиж, зөв ойлгох боломж бүхий хэмжээтэй байна.

Жич: 2 мм-ээс ихгүй хэмжээтэй цифр, хүрээтэйгээ 10 мм-ээс ихгүй хэмжээтэй зурган тэмдэглэгээг (цагаан дээр хараар бичсэн) хийж ашиглахыг зөвлөж байна.

f) Ашиглалтын заавар дараах агуулгатай байна. Үүнд:

- Шаардлагатай тохиолдолд өмсөж тайлах заавар

- Ашиглалтанд тавих хязгаарлалт (өмсөх нормт хугацаа, ашиглалтын дараа устгах заавар г.м)
- Хадгалах, арчлах заавар
- Хувцасны материалын онцлогт тохирсон цэвэрлэгээний заавар (угаах горим, химийн цэвэрлэгээний бодис, индүүдэх температурын хязгаарлалт г.м)

7.2.6 Хувцасны сав баглаа боодолд тавих шаардлага

a) Хувцас тус бүрийг (хос бол иж бүрдүүлж) тусгай зориулалтын гялгар уутанд савлан, хэд хэдээр нь багцалж хайрцаглана.
b) Үйлдвэрлэгч барааны дагалдах хуудсыг хоёр хувь бичиж, нэг хувийг хайрцагны дотор талд хийж, хоёр дахь хувийг хайрцагны гадна талд наана. Дагалдах хуудсанд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо ширхэг, үйлдвэрлэгчийн нэр хаяг, огноог бичсэн байна.
c) Хайрцагны хажуу талд ус, чийгнээс хамгаалахыг анхааруулсан таних тэмдгийг тод өнгөөр тэмдэглэсэн байна.

7.2.7 Хувцсыг хүлээн авах, шалгахад тавих шаардлага

a) Бэлэн болсон хувцсыг энэхүү стандарт болон холбогдох тус тусын стандартад заасан үзүүлэлт, шаардлага, захиалагчийн баталсан загварын дагуу шалгаж хүлээн авна.
b) Хувцасны хог, тоос, утасны үзүүрийг түүж цэвэрлэсэн байна.
c) Захиалагч тал бэлэн бүтээгдэхүүнийг багцаар хүлээн авна. Багц нь дагалдах бичигтэй, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээнд заагдсан тооны хувцас байна.
d) Багц дахь бүтээгдэхүүний тооноос хамааруулан санамсаргүйгээр дээж сонгож чанарын шалгалтыг явуулна.

7.4-р хүснэгт

Түүвэрлэх дээжний тоо

№	Бэлэн бүтээгдэхүүний тоо, ш	Чанарыг шалгах дээжний тоо, ш
1	50 хүртэл	5
2	150 хүртэл	20
3	500 хүртэл	50
4	1200 хүртэл	80
5	3200 хүртэл	125

e) Түүвэрлэж авсан дээж - хувцас нэг бүрийг хувцасны нэр төрөл, шинж чанар, материал сонголт, өмсгөл хэмжээ, хийц, технологийн шаардлагад тохирч байгаа эсэхийг шалгасан байна.
f) Бэлэн бүтээгдэхүүний чанарыг шаардлага хангасан манекен ашиглаж эсвэл ширээн дээр дэлгэж тавиад нүдээр харж, зориулалтын мэргэжлийн багаж хэрэгслийн тусламжтайгаар шалгана.
g) Бүтээгдэхүүний шугаман хэмжээг металл шугамаар хэмжинэ. Хэрэглэгдэж байгаа шугам нь стандартын шаардлага хангасан байх ба механик гажилт болон элэгдэлтэнд ороогүй байна.
h) Захиалагч байгууллага шаардлагатай гэж үзвэл үйлдвэрлэгч үйлдвэрлэсэн хувцасны чанарын үзүүлэлтийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулсан байна.
i) Хувцас хүлээн авах явцад захиалагч, ханган нийлүүлэгч, үйлдвэрлэгч байгууллагуудын хооронд гарсан маргааныг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

7.3 Хавар, намрын болон өвлийн хувцас. Техникийн шаардлага

7.3.1 Ерөнхий шаардлага, ангилал, иж бүрдэл

Хавар, намрын болон өвлийн тусгай хувцсыг энэхүү хувцсанд тавигдах ерөнхий шаардлагад нийцүүлэн, батлагдсан эх загвар, ЗТББ-06, ЗТББ-07 загварын техникийн баримт бичгүүдийн дагуу үйлдвэрлэнэ.

Иж бүрдэл

Хавар, намрын тусгай хувцас нь хүрэм байна.

Өвлийн тусгай хувцас нь хүрэм, мөрөвчтэй өмднөөс бүрдсэн хослол байна.

Ангилал

Хавар, намрын хүрэм нь дараах загварууд байна:

- АХЗҮГ-ын ажилтанд зориулсан хүрэм (**загварын дугаар ТХ-ХН-01)**
- ГҮАЕМХХН-ийн ажилтанд зориулсан хүрэм (**загварын дугаар ТХ-ХН-02)**

- Бусад хэлтэс, нэгжийн ажилтнуудад зориулсан хүрэм (**загварын дугаар ТХ-ХН-03**).
Өвлийн хослол нь дараах загварууд байна:
- АХЗҮГ-ын ажилтанд зориулсан өвлийн хүрэм, мөрөвчтэй өмд (**загварын дугаар ТХ-Ө-01)**
- ГҮАЕМХХ-ийн ажилтанд зориулсан өвлийн хүрэм, мөрөвчтэй өмд (**загварын дугаар ТХ-Ө-02)**
- Бусад хэлтэс, нэгжийн ажилтнуудад зориулсан өвлийн хүрэм, мөрөвчтэй өмд (**загварын дугаар ТХ-Ө-03**).

7.3.2 Хувцасны өмсгөл хэмжээ

Хавар-намрын болон өвлийн тусгай хувцасны өмсгөл хэмжээний ангилал нь энэхүү стандартын 7.2.1-д заасан ангилалтай тохирно.
Хувцасны төрөл, зориулалтаас хамааран хувцасны суурь үлгэрийн зохион бүтээлтэд ашиглах сулын оновчтой хэмжээ нь А2 хавсралтын 1-р хүснэгтэд заасан хязгаарт байна.

7.3.3 Техникийн шаардлагууд

Хавар-намрын болон өвлийн тусгай хувцас нь энэхүү стандартын 7.2.2-д заасан техникийн ерөнхий шаардлагуудыг хангасан байна.
Өвлийн хувцас нь орчны нөхцөлд тохирсон дулаан хадгалах чадвартай, хөнгөн жинтэй байна. Хүний биеэс гарах хөлс чийгийг шингээж, хөлөргөдөггүй байна.
Хувцасны гадаад байдал нь ""МИАТ" ТӨХК-ийн ажилтнуудын ажлын тусгай зориулалтын хувцасны загвар"-ын альбомд тусгасан техникийн зургуудтай тохирч байна.
Хувцасны логонд тавих шаардлага нь энэхүү стандартын 7.2.2.4-д заасантай нийцнэ.

7.3.4 Хувцасны материалд тавих шаардлага

7.3.4.1 Хувцасны гадар материалд тавих шаардлага

Хавар намар, өвлийн ажлын хувцасны гадар материал нь гадны механик үйлчлэлд тэсвэртэй, салхи нэвтрүүлэлт нь зохих түвшинд, гаднаас ус чийг нэвтрүүлэхгүй байна.

Өвлийн ажлын хувцасны гадар материал нь гадны механик үйлчлэлд тэсвэртэй, салхи нэвтрүүлэлт нь зохих түвшинд байх, гаднаас ус чийг нэвтрүүлэхгүй, хөлддөггүй байна.

Хавар намрын болон өвлийн ажлын хувцасны гадар материалын физик механик шинж чанарын нийтлэг үзүүлэлт нь 7.5-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

7.5-р хүснэгт

Өвлийн болон хавар, намрын тусгай хувцасны гадар материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга	
		Хавар, намрын хувцас	Өвлийн хувцас
1	Ширхэгтийн бүрэлдэхүүн, %	Байгалийн ширхэгт 30%-иас багагүй, Хиймэл ширхэгт 70%-иас ихгүй	Полиэстер 80%-иас багагүй, Полиамид 20%-иас ихгүй
2	Гадаргуугийн нягт, г/м^2, багагүй	200	200
4	Зузаан, мм, ихгүй	0.6	0.6
5	Тасралтын даац, Н, багагүй - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 780 650	 600 400
6	Урагдалт тэсвэрлэлт, Н, багагүй - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 30 25	 30 25
7	Будгийн тогтвор, оноо, дээш - хуурай цэвэрлэгээнд - угаалтанд - нарны гэрэлд	4	4
8	Агаар нэвтрүүлэлт, дм^3 /м^2 с, ихгүй	40	40
9	Ус түлхэх чадвар, нэгж, ихгүй - эхэн үед - 5 угаалтын дараа	 90 80	 90 80
10	5 удаагийн угаалтын дараах агшилт, %,	±2.0	±2.0

11	Угаалт тэсвэртэй байдал, эргэлт, багагүй	3000	3000

Салхины хамгаалалтын давхаргын уур нэвтрүүлэлт 4.0 мг/(см*цаг)-аас багагүй байна.

7.3.4.2 Дотрын материалд тавих шаардлага

Хувцасны дотрын зориулалтаар ашиглах материалд 7.6-р хүснэгтэд заасан шаардлагуудыг тавина.

7.6-р хүснэгт

Дотрын материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга
1	Хиймэл ширхэгтийн агууламж, %, багагүй	80-100
2	Гадаргуугийн нягт, г/м^2, багагүй	110
3	Тасралтын даац, Н, багагүй: - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 210 160
4	Чийг шингээх чадвар, %, багагүй	7
5	Агаар нэвтрүүлэлт, Дм/ (м*сек), багагүй	100
6	Угаалтын дараах агшилт, %, ихгүй - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 -3.5 ±2.0
7	Будгийн тогтвор, оноо, дээш - хуурай цэвэрлэгээ, угаалга, хөлс, хими цэвэрлэгээ	4

7.3.4.3 Хувцасны дулаалгын материалд тавих шаардлага

Хувцасны дулаалганд зузаан болон давхаргын тоогоор шаардлагатай дулаан хадгалах чадварыг хангаж чадах, шаталтыг дэмждэггүй ямар ч төрлийн дулаалгын материал ашиглаж болно: нэхээсгүй дулаалгууд (тэмээний ноос, синтефон, тинсулейт зэрэг төрөл бүрийн ширхэгтээр үйлдвэрлэгдсэн), хөвөн, өд сөдөн дулаалга (дүүргэгч) г.м.

Дулаалгын материал нь 7.7-7.9-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

7.7-р хүснэгт

Дулаалгын материалд тавигдах шаардлага

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга
1	Гадрын болон дотрын материалыг дулаалгын ширхэгтийн нэвчин гарах	150 см^2 талбайд хоёроос ихгүй ширхэгт
2	Чийг шингээх чадвар, %, багагүй	3

Өвлийн хувцасны дулаалгын материалын ширхэгтийн холио нь байгалийн ширхэгт (хөвөн, ноос) нэг давхарлагад 50%-аас багагүй байна.

Түгээмэл хэрэглэгдэж буй синтетик болон малын гаралтай ноосон ширхэгтэн дулаалгын материалын шинж чанарын үзүүлэлтүүд 7.8, 7.9-р хүснэгтэд заасантай тохирсон байна.

7.8-р хүснэгт

Синтетик дулаалгын материалын шинж чанарын үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр		Үзүүлэлтийн утга
1	Гадаргуун нягт, г/м^2		80-200
2	Жин, ounce (Oz)*	Ар энгэрт	8
		Ханцуй, өмдний бүрдэл хэсэгт	5
		Халаасны таг, цахилгааны даралт, зах бусад хэсэгт	2
3	Жингийн жигд бус байдал, %		±10
4	Агшилт, % - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу		±2.5
Тайлбар: * нь жингийн нэгжийг грамм руу шилжүүлэхдээ 0.035-аар үржүүлнэ.			

7.9-р хүснэгт

Малын гаралтай ноосон ширхэгтэн дулаалгын материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга
1	Гадаргуун нягт, г/м^2	200-240
2	Зузаан, мм	12-24
3	Сүвэрхэг байдал, %, багагүй	10

7.3.4.4 Туслах материалд тавих шаардлага

a. Туслах материал болох цахилгаан товч, товч, зангуу нь хүйтэн нөхцөл, хими цэвэрлэгээ, индүүдлэг даах чадвартай байна**.**

b. Хувцасны туслах тоноглол, оёдлын утасны өнгө нь гадар материалын өнгөтэй зохицсон байна.

c. Гэрэл цацруулагч туузанд тавих шаардлага нь А4 хавсралтын 1-р хүснэгтэд заасантай нийцсэн байна.

7.3.5 Хамгаалах шаардлага

7.3.5.1 Өвлийн хувцасны хийцэд MNS 6306:2012-д заасан хүйтнээс хамгаалах дараах шийдлүүдийг тусгаж өгнө. Үүнд:

- Үндсэн бүтээгдэхүүний товчлоосон дээр салхинаас хамгаалах дулаалгатай хаалт (планк), дотор талд дулаан хадгалах зориулалттай, нэмэлт хаалт (цахилгааны хязгаарлалттай) хийж өгнө.
- Нүүрний ухлаадасны хэмжээг тохируулагч саалт бүхий дулаалгатай, салдаг юүдэнтэй байх.
- Хүрэмний дулаалгатай дотрын ханцуйны үзүүрт сүлжмэл манжеттай байх
- Өмд нь дулаалгатай өргөн бүстэй байх
- Ширмэл синтефон дотортой байх
- Бүсэлхийн хэсэгт бие барих байдлыг тохируулах боломжтой байх (бүсэлхийд саадаг бүс г.м).

7.3.6. Бэлтгэхэд тавих шаардлагууд

7.3.6.1 Хувцсыг энэхүү стандартын 7.2.4-д заасан шаардлагуудад нийцүүлэн, зохих журмын дагуу батлагдсан эх загвар, техникийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэнэ.

7.3.6.2 Даавууны суурь утасны чиглэл, зөвшөөрөгдөх хазайлтын хэмжээг ЗТББ-д заасан байна.

7.3.6.3 Дулаалгатай дотрын урт өргөн нь гадар бүрдэл хэсгийн хэмжээтэй таарч байх ёстой.

7.3.6.4 Дулаалгын ширээсгүй материалын хувьд давхаргуудыг 12,0 см зайтай параллель оёдлуудаар ширж оёсон байна.

7.3.6.5 Энгэрийн товчлоосны салхинаас хамгаалах хаалтны өргөн 8,0 см-аас багагүй, юүдэнгийн эрүүний хэсгийн өргөн 8,0 см-аас багагүй, дотрын сүлжмэл манжетны өргөн 8,0 см-аас багагүй, дулаалгатай бүсний өргөн (ууцны хэсэгт) 12,0 см-аас багагүй байна.

7.3.7 Хувцасны хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд

Хувцасны үйлдвэрлэх, хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд нь энэхүү стандартын:

- 7.2.5-д заасан “Хувцасны шошгонд тавих шаардлага”,
- 7.2.6-д заасан “Хувцасны сав баглаа боодолд тавих шаардлага”,
- 7.2.7-д заасан ”Хувцсыг хүлээн авах, шалгахад тавих шаардлага”-ыг хангасан байна.

7.4 Зуны тусгай хувцас. Техникийн шаардлагууд

7.4.1 Ерөнхий шаардлага, иж бүрдэл
Зуны тусгай хувцас нь бүх улирлын хэрэглээнд зориулагдсан бөгөөд энэхүү стандартад заасан шаардлагуудад нийцүүлэн, батлагдсан эх загвар, ЗТББ-04 загварын техникийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэнэ.

Иж бүрдэл
Зуны тусгай хувцас нь хүрэм ба өмднөөс бүрдсэн хослол байна.

7.4.2 Нэр төрөл, ангилал
Зуны тусгай хувцас буюу үйлдвэрлэлийн ерөнхий бохирдол, механик үйлчлэлээс хамгаалах хувцсыг ашиглалтын нөхцлөөс нь хамааран хамгаалах түвшнээр нь 2 ангид хуваана:

1. Үйлдвэрлэлийн ерөнхий бохирдлоос хамгаалах тусгай хувцас. Үүнд: Газрын үйл ажиллагааны ерөнхий менежерийн харьяа хэлтэс, нэгжийн ажилтнуудын ажлын тусгай хувцас, бусад хэлтэс, нэгжийн ажилтнуудын тусгай хувцас, халад орно.
2. Механизмын хөдөлгөөнт хэсгүүдээс хамгаалах тусгай хувцас. Үүнд: Агаарын хөлгийн засвар үйлчилгээний ажилтнуудын тусгай хувцас орно.

Зуны хослол нь дараах загварууд байна:
- АХЗҮГ-ын ажилтанд зориулсан зуны хослол (загварын дугаар ТХ-З-01);
- ГҮАЕМХХН-ын ажилтанд зориулсан зуны хослол (загварын дугаар ТХ-З-02);
- Бусад хэлтэс, нэгжийн ажилтнуудад зориулсан зуны хослол (загварын дугаар ТХ-З-03);
- Халад (загварын дугаар ТХ-Х-01).

7.4.3 Хувцасны өмсгөл хэмжээ
7.4.3.1 Хувцасны өмсгөл хэмжээний ангилал нь энэхүү стандартын 7.2.1-д заасан ангилалтай тохирно.
7.4.3.2 Бэлэн бүтээгдэхүүний үндсэн хэмжээсүүдийг хэмжих байрлалууд, тэдгээрийн утгууд, хазайлтын хязгаарыг хувцасны загварын техникийн баримт бичигт тусгасан байна.
7.4.3.3 Хувцасны зохион бүтээлтэд ашиглах зохион бүтээлтийн сулын хэмжээний оновчтой утгууд нь А3 хавсралтын 1-2-р хүснэгтэд үзүүлсэнтэй тохирно.

7.4.4 Техникийн шаардлагууд
Зуны хувцас нь энэхүү стандартын 7.2.2-д заасан Техникийн шаардлагуудыг хангаж байна.
Хувцасны гадаад байдал нь ""МИАТ" ТӨХК-ийн ажилтнуудын ажлын тусгай зориулалтын хувцасны загвар"-ын альбомд тусгасан техникийн зургуудтай тохирч байна.
Хувцасны лого нь энэхүү стандартын 7.2.2.4-д заасан шаардлагуудад нийцнэ.

7.4.5 Хувцасны материалд тавих шаардлагууд

7.4.5.1 Зуны тусгай хувцас үйлдвэрлэхэд ашиглах материалууд нь тухайн зориулалтын хувцасны хамгаалах шинж чанарыг хангах үзүүлэлтүүдтэй байна.

7.4.5.2 Хүний эрүүл мэндэд хортой формальдегид, хүнд металл, фенол, хориглосон будаг, харшил өгдөг будаг агуулаагүй, таагүй үнэргүй, хортой бодис ууршуулдаггүй, pH хэвийн байх нэмэлт шаардлага хангасан байна.

7.4.5.3 Материалын нойтон боловсруулалтын дараах өөрчлөлтийн хэмжээ нь суурь утасны дагуу -3.5%-аас, хөндлөн утасны дагуу ± 2.0%-аас хэтрэхгүй, байна.

7.4.5.4 Даавууны хамгаалалтын шинж чанарын үзүүлэлт нь таван удаагийн угаалга эсвэл таван удаагийн хуурай хими цэвэрлэгээнд орсны дараа хадгалагдана. Угаах эсвэл хуурай хими цэвэрлэгээний дараа хамгаалалтын шинж чанарын үзүүлэлтийн бууралт 20% -иас хэтрэхгүй байна.

7.4.5.5 Зуны хувцасны (хүрэм, өмд) болон халадны материал нь 7.12-р хүснэгтэд заасан шаардлагуудыг хангасан байна.

7.12-р хүснэгт

Зуны хувцасны болон халадны материалд тавих шаардлага

	Үзүүлэлтийн утгууд

Үзүүлэлтийн нэр	АХЗҮГ ажилтнуудын хувцас **ТХ-З-01**	ГҮАЕМХХН ажилтнуудын хувцас **ТХ-З-02**	БХН-ийн ажилтнуудын хувцас **ТХ-З -03**	Халад **ТХ-Х-01**
Ширхэгтийн бүрэлдэхүүн, *%, багагүй*	Хөвөн - 35%, Полиэстр - 65%, цэнэгждэггүй (антистатик утас)	Хөвөн- 35%, Полиэстр -65%, антистатик утас	Хөвөн- 35%, Полиэстр -65%, антистатик утас	Хөвөн- 100%
Гадаргуугийн нягт, *г/м²*	300-с ихгүй	245-270	245-270	142
Агаар нэвтрүүлэлт, *дм³/м² с, багагүй*	20	20	20	100
Чийг шингээлт, *%-с багагүй*	5	5	5	15
Тасралтын даац, *Н, багагүй* - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	1000 600	1000 600	1000 600	216 147
Элэгдэлт тэсвэрлэлт, *эргэлт, багагүй:*	700	700	700	-
5 удаагийн угаалтын дараах агшилт, *%, ихгүй* - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	-3,5 ±2,0	-3,5 ±2,0	-3,5 ±2,0	±2,0 ±2,0
Тос үл нэвчилт, *оноо, багагүй*	5	5	5	5
5 удаагийн угаалга эсвэл 5 удаагийн хуурай цэвэрлэгээний дараах тос үл нэвчилт, *оноо, багагүй*	4	4	4	4

Физик химийн үйлчлэлд будгийн тогтвор, балл - гэрэлд - угаалганд - хөлсөнд - хуурай/нойтон үрэлтэнд органик уусгагчид	5 4 4 4/4 4	5 4 4 4/4 4	5 4 4 4/4 4	- 3 4 3/3 3

7.4.5.7 Туслах материалд тавих шаардлага

a) а) Туслах материал болох цахилгаан товчлоос, товч, зангуу нь олон удаагийн угаалт, цэвэрлэгээг тэсвэрлэх чадвартай байна.
b) Хувцасны туслах тоноглол, оёдлын утасны өнгө нь гадар материалын өнгөтэй зохицсон байна.
c) Цахилгаан товчлоос нь удаан эдэлгээтэй, аюулгүй материалаар хийгдсэн байна.
d) 200-400 *г/м²* гадаргуугийн нягттай материалд Т6, П10, Л10 төрлийн цахилгаан товчлоос хэрэглэнэ.
e) Хүрэмний цахилгаан товчлоосны бат бөхийн үзүүлэлт ба түгжээний хөдөлгөөний хүч нь 7.13-р хүснэгтэд заасан шаардлагуудыг хангасан байна.

7.13-р хүснэгт

Үзүүлэлтийн нэр	Цахилгаан товчлоосны төрөл		
	Т6	П10	Л10
Хаалттай холбоосыг таслах хүч, Н, багагүй	150	150	100
Түгжээний бөх бат, Н, багагүй	120	120	120
Доод хязгаарлагчийн холболтын хүч, Н, багагүй	70	60	100
Доод хязгаарлагчийн зүсэлтийн хүч, Н, багагүй	80	80	60
Дээд хязгаарлагчийн түгжээний бэхэлгээний хүч	80	80	60
Түгжих хөдөлгөөний хүч, Н, ихгүй	8	5	8

7.4.6 Бэлтгэхэд тавих шаардлагууд

7.4.6.1 Хувцсыг энэхүү стандартын шаардлагуудад нийцүүлэн, батлагдсан эх загвар, ЗТББ-04 загварын техникийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэнэ.

7.4.6.2 Даавууны суурь утасны чиглэл, зөвшөөрөгдөх хазайлтын хэмжээг ЗТББ-д заасан байна.

7.4.6.3 Гэрэл цацруулагч туузанд тавих шаардлага нь А4 хавсралтын 1-р хүснэгтэд заасантай нийцсэн байна.

7.4.6.4 Тодорхой үйлдвэрлэлийн нөхцлийн онцлогоос хамааран хувцсанд нэмэлт шаардлагууд тавигдах тохиолдолд техникийн нөхцлийн дагуу бэлтгэж болно. (жишээ нь, дохиоллын, антистатик, тоос, ус нэвтэрдэггүй, гагнуурын очноос хамгаалах г.м).Техникийн нөхцөлд энэ стандартын шаардлагуудыг бууруулсан шаардлага байж болохгүй.

7.4.7 Хувцасны үйлдвэрлэх, хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд

Зуны хувцасны үйлдвэрлэх, хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд нь энэхүү стандартын:
- 7.2.4-д заасан “Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд тавих шаардлагууд”,
- 7.2.5-д заасан “Хувцасны шошгонд тавигдах шаардлага”,
- 7.2.6-д заасан “Хувцасны сав баглаа боодолд тавих шаардлага”,
- 7.2.7-д заасан ”Хувцсыг хүлээн авах, шалгахад тавигдах шаардлага”-ыг хангасан байна.

7.5 Борооны цув. Техникийн шаардлага

7.5.1 Ерөнхий шаардлага, иж бүрдэл

Борооны цувыг энэхүү стандартад заасан шаардлагуудад нийцүүлэн, батлагдсан эх загвар, ЗТББ-05 загварын техникийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэнэ.

7.5.2 Ангилал

Борооны цувыг (загварын дугаар ТХ-БЦ-01):
- эрэгтэй хүний,
- эмэгтэй хүний гэж ангилна.

7.5.3 Хувцасны өмсгөл хэмжээ

7.5.3.1 Хувцасны өмсгөл хэмжээний ангилал нь энэхүү стандартын 7.2.1-д заасан ангилалтай тохирно.

7.5.3.2 Бэлэн бүтээгдэхүүний үндсэн хэмжээсүүдийг хэмжих байрлалууд, тэдгээрийн утгууд, хазайлтын хязгаарыг хувцасны загварын техникийн баримт бичиг ЗТББ-05-д тусгасан байна.

7.5.4 Техникийн шаардлагууд

Борооны цув нь энэхүү стандартын 7.2.2-д заасан Техникийн шаардлагуудыг хангаж байна.
Хувцасны гадаад байдал нь ““МИАТ” ТӨХК-ийн ажилтнуудын ажлын тусгай зориулалтын хувцасны загвар”-ын альбомд тусгасан техникийн зургуудтай тохирч байна.
Хувцасны логод тавих шаардлага нь энэхүү стандартын 7.2.2.4-д заасантай нийцнэ.

7.5.4 Материалд тавих шаардлага

7.5.4.1 Борооны цувны өнгөний материалд тавигдах шаардлагууд нь 7.14-р хүснэгтэд заасантай нийцнэ.

7.14-р хүснэгт

Борооны цувны өнгөний материалд тавих шаардлагууд

Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга
Гадаргуугийн нягт, г/м^2	170-200
Ширхэгтийн бүрэлдэхүүн, %,	100% Полиэстер (1 болон 2 талдаа поливинилхлорид-түрхлэгтэй)
Тасралтын даац, Н, *багагүй:* - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 1000-1200 900-800
Үрэлтийн хүч, Н, багагүй - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 250 200
Элэгдэлт тэсвэрлэлт, эргэлт - химийн ширхэгттэй даавуунд	 500-1500
Агаар нэвтрүүлэлт, мг/см^2 цаг	30-50
Угаалганы дараах агшилт, %, ихгүй - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 ± 2.0 ± 2.0
Будгийн тогтвор, оноо	Тогтвортой

- угаалганд, хуурай үрэлтэнд, химийн цэвэрлэгээнд	
Материалын шинж чанар	Цувны материал нь ус чийг нэвтрүүлэхгүй шинж чанартай байна. Түрхлэг ба нэхмэл материал

7.5.4.2 Бүтээгдэхүүн дээр оёгдох гэрэл ойлгогч материалын эзлэх хамгийн бага талбайн хэмжээ 7.15-р хүснэгтэд заасантай нийцнэ.

7.15-р хүснэгт

Материалын нэр төрөл	Борооны цувны материал, м^2
Үндсэн материал	0,50
Гэрэл ойлгогч материал	0,13

7.5.4.2 Гэрэл ойлгогч материалын өргөний хэмжээ нь 50 мм-ээс багагүй байх ба мөр болон бүсний хэсэгт 30 мм-ээс багагүй байна.

7.5.5 Бүтээгдэхүүнд тавих шаардлага

7.5.5.1 Зориулалтдаа тохирох шаардлага

a) Цув (борооны)-ыг ажлын хувцасны гадуур өмсөнө.
b) Борооны цувны оёдлуудын дагуу ус нэвтрүүлэхгүй тусгай наалт нааж боловсруулсан байна.
c) Борооны цувны гэрэл ойлгогч цацруулагчийн хэмжээ, байрлал нь техникийн тодорхойлолтонд заасантай тохирно.
d) Байгууллагын товчилсон нэр бүхий таних тэмдэгийг борооны цувны дээд хэсэгт голлуулан байрлуулна.
e) Бүтээгдэхүүний оёдлын чанарт тавигдах шаардлагууд нь ISO-4915: 1991, MNS ISO 4916:2011, MNS 6344:2012-д нийцсэн байна.

7.5.5.2 Эрүүл ахуй, аюулгүйн тусгай шаардлага

a) Хувцас нь эрүүл ахуйн шаардлага хангасан, ус чийгнээс хамгаалах хийцтэй байна.
b) Хувцасны хийц нь ус, чийг хувцасны дотор тал руу үсрэх, урсах, нэвтрэх, нэвчихээс хамгаалсан байна.
c) Хувцасны гадаргуу нь ус тогтохоргүй толигор байна.
d) Хувцасны гадаргууд тоног төхөөрөмж гэх мэт зүйлтэй ороцолдох, дэгээдэгдэх бүч гэх мэт сул үзүүр байх ёсгүй.
e) Борооны цув нь гэрэлтүүлэгчтэй, тод ялгарч харагдах өнгөтэй байна.
f) Аюул тохиолдсон үед шаардлагатай бол тайлахад хялбар хийцтэй байна.

7.5.6 Хувцасны үйлдвэрлэх, хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд

Борооны цувны үйлдвэрлэл, хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд нь энэхүү стандартын:
- 7.2.4-д заасан “Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд тавих шаардлагууд”,
- 7.2.5-д заасан “Хувцасны шошгонд тавих шаардлага”,
- 7.2.6-д заасан “Хувцасны сав баглаа боодолд тавих шаардлага”,
- 7.2.7-д заасан ”Хувцсыг хүлээн авах, шалгахад тавигдах шаардлага”-ыг хангасан байна.

7.6 Дохиоллын хантааз. Нэмэлт шаардлагууд

Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь тус байгууллагын гадаад орчинд ажилладаг ажилтны ажлын талбай дээр ажил үүргээ эсвэл түүнтэй ижил төстэй үүрэг гүйцэтгэж буй тохиолдолд бусдад урьдчилан анзаарагдах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тусгай зориулалтын дохиоллын хантаазанд хамаарна.

7.6.1 Ерөнхий шаардлага, иж бүрдэл

Дохиоллын хантаазыг энэхүү стандартад заасан шаардлагуудад нийцүүлэн, батлагдсан эх загвар, ЗТББ-11 загварын техникийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэнэ.

7.6.2 Ангилал

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах тусгай зориулалтын дохиоллын хантаазыг түүн дээрхи дохиоллын элементүүд /цацруулагч туузнууд/-н эзлэх талбайн хэмжээнээс нь хамааруулан 3 ангилна.

Хантаазны ангилал тус бүрт үндсэн материал ба цацруулагч материалаар хийх дохиоллын элементүүдийн эзлэх хамгийн бага талбай ($м^2$) нь 7.16-р хүснэгтэд заасан хэмжээнээс багагүй байна.
Дохиоллын хантааз нь үндсэн болон цацруулагч материалаар хийгдсэн шаардлагатай талбай бүхий дохиоллын элементийг агуулахаас гадна зөвхөн хосолсон материалаар хийгдэж болно.

7.16-р хүснэгт

Дохиоллын элементүүдийн эзлэх талбайн хамгийн бага хэмжээ, $м^2$

Материалын нэр	III ангиллын хантааз	II ангиллын хантааз	I ангиллын хантааз
Үндсэн материал	0.8	0.50	0.14
Цацруулагч материал	0.2	0.13	0.10
Хосолсон материал	-	-	0.20

Жич: III-р ангилалын хантааз нь II-р ангилалын хантаазтай харьцуулахад илүү их тод ялгаралттай байх ёстой. Харин II-р ангилалын хантааз нь I-р ангилалын хантаазнаас илүү тод ялгаралттай байна.

Дохиоллын хантаазан дээрхи дохиоллын элементүүдийн байршилд тавих шаардлагыг А5 хавсралтын 1-3-р зурагт үзүүлэв.
“МИАТ”ТӨХК-ийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны байдлыг хангах дохиоллын хантаазны загваруудыг А5 хавсралтын 7-9-р зурагт үзүүлэв.

7.6.3 Хантаазны материалд тавих шаардлага

7.6.3.1 Өнгөний шийдэл

Гадаа орчинд ажилладаг ажилтны дохиоллын хантаазны үндсэн материалын болон дохиоллын элементийн өнгө нь ажлын байр, албан тушаалаас хамаарахгүйгээр ижил байна.
Хантаазны ар, энгэр болон бусад жижиг бүрдэл хэсгүүд нь:

- Неон шар /Safety yellow, Pantone 16-0630 TN өнгөтэй тохирно.

Хантаазны дохиоллын элемент нь:

- Саарал /Frost Gray, Pantone 17-0000 TPX өнгөтэй тохирно.

7.6.3.2 Хантаазны үндсэн материалд тавих шаардлага

a) Дохиоллын хантаазны их биений үндсэн материалд байгалийн гэрэлд болон өдрийн гэрэлд хамгийн сайн, тод ялгарч харагдах гурван үндсэн өнгийг сонгож болно. Ажилтны ажлын орчин, ажлын талбарын зонхилж буй өнгөнөөс хамааран түүнээс хамгийн их ялгарч харагдаж буй өнгийг сонгоно.
b) Үндсэн материалын өнгөний шинж чанарууд нь 7.17-р хүснэгтэд заасан өнгөний координатын байж болох хослолуудын аль нэгтэй тохирч байх ёстой. Гэрэлтэлтийн коэффициент нь 7.17-р хүснэгтэд заасан хамгийн бага утгаас их байна.

7.17-р хүснэгт

Хантаазны үндсэн материалын өнгөний шинж чанар

д/д	Үндсэн материалын өнгө	Өнгөнийкоординат		Гэрэлтэлтийн коэффициент,β (хамгийн бага утга)
		X	Y	
1	Тод шар Fluorescent	0.387 0.356 0.398 0.460	0.610 0.494 0.452 0.540	0.76
2	Тод улбар шар Fluorescent	0.610 0.544 0.579 0.655	0.390 0.376 0.341 0.344	0.40
3	Тод улаан Fluorescent	0.655 0.579 0.606 0.690	0.344 0.341 0.314 0.310	0.25

c) Хосолсон үндсэн материалын өнгөний шинж чанарууд нь 7.18-р хүснэгтэд заасан өнгөний координатын байж болох хослолуудын аль нэгтэй тохирч байх ёстой. Гэрэлтэлтийн коэффициент нь 7.18-р хүснэгтэд заасан хамгийн бага утгаас их байна.

7.18-р хүснэгт

Хосолсон материалын өнгөний шинж чанар

д/д	Өнгө	Өнгөний координат		Гэрэлтэлтийн коэффициент, β (хамгийнбага утга)
		X	Y	
1	Тодшар Fluorescent	0.387 0.356 0.398 0.460	0.610 0.494 0.452 0.540	0.76
2	Тод улбаршар Fluorescent	0.610 0.535 0.570 0.655	0.390 0.375 0.340 0.344	0.40
3	Тод улаан Fluorescent	0.655 0.570 0.595 0.690	0.344 0.340 0.315 0.310	0.25

d) Үндсэн материал болон хосолсон материалын өнгө нь гэрлийн үйлчлэлд тэсвэртэй байна. Ксенон чийдэн буюу хурц хиймэл гэрэлтүүлгийн гэрэлд материалыг тодорхой хугацаанд байлгасны дараа өнгөний координат ба гэрэлтэлтийн коэффициент нь 7.19-7.20-р хүснэгтэд заасан утгатай тохирч байна.

Хантаазны үндсэн материалын физик-химийн үзүүлэлтүүд нь 7.19-р хүснэгтэд заасан шаардлагуудад нийцнэ.

7.19-р хүснэгт

Үндсэн материалын физик-химийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга
1	Гадаргуугийн нягт, г/м^2, багагүй	200
2	Агаар нэвтрүүлэлт*, дм^3/м^{2}с, ихгүй	40
3	Урагдалт тэсвэрлэлт, Н, багагүй: - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 30 25
4	Элэгдэлт тэсвэрлэлт**, эргэлт, багагүй: - сүлжмэл даавуу - нэхмэл даавуу	 350 500
5	Тасралтын даац, Н, багагүй: - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 850 650
6	Угаалтын дараах агшилт, % , ихгүй: - суурь утасны дагуу - хөндлөн утасны дагуу	 ±3,0 ±3,0
7	Будгийн тогтвор, оноо, багагүй - Гар угаалга - Хими цэвэрлэгээ - Индүүдлэг	 4,0-5,0 4 3-4
8	Ус нэвтрүүлэлт, Па, багагүй	8000

e) Хантаазанд ашиглах материалууд нь эрүүл ахуйн нормативуудыг хангасан байна.

f) Тусгай болон хосолсон материалын гэрэл ойлгох шинж чанарт тавих шаардлага: гэрэл ойлгох хамгийн бага коэффициент нь материалын төрлөөс хамаарч 7.20-7.22-р хүснэгтүүдэд заасан шаардлагад нийцсэн байна.

7.20-р хүснэгт

II ангиллын цацруулагч материалын гэрэл ойлгох хамгийн бага коэффициент, кд/(люкс*м^2)

Харах өнцөг	Гэрэлтүүлэх өнцгийн гэрэл ойлгох хамгийн бага коэффициент			
	5 °	20 °	30 °	40 °
12 '	330	290	180	65
20 '	250	200	170	60
1 °	25	15	12	10

1 ° 30 '	10	7	5	4

7.21-р хүснэгт

I ангиллын цацруулагч материалын гэрэл ойлгох хамгийн бага коэффициент, кд/(люкс*м²)

Харах өнцөг	Гэрэлтүүлэх өнцгийн гэрэл ойлгох хамгийн бага коэффициент			
	5 °	20 °	30 °	40 °
12 '	250	220	135	50
20 '	120	100	75	30
1 °	25	15	12	10
1 ° 30 '	10	7	5	4

7.22-р хүснэгт

Хосолсон материалын гэрэл ойлгох хамгийн бага коэффициент, кд/(люкс*м²)

Харах өнцөг	Гэрэлтүүлгийн өнцгийн гэрэл ойлгох хамгийн бага коэффициент			
	5 °	20 °	30 °	40 °
12 '	65	50	20	5
20 '	25	20	5	1.75
1 °	5	4	3	1
1 ° 30 '	1.5	1	1	0.5

Жич: Хосолсон материалын гэрэл ойлгох коэффициентийн утга нь материалын өнгө харгалзахгүй тохирно.

g) Дохиоллын хантаазны материал нь гэрэл ойлгох шинж чанараа эдэлгээний нормт хугацааны туршид алдахгүй байна.
h) Зуны улиралд өмсөх зориулалттай дохиолллын хантаазны үндсэн материалыг уг стандартын шаардлагад нийцсэн агаар, салхи чөлөөтэй нэвтрүүлэх сүвэрхэг материалаар хийж болно.

7.6.4 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тавих шаардлага

7.6.4.1 Ерөнхий шаардлага

Гадаад орчинд ажилладаг ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах дохиоллын хантаазыг тухайн ажиллах орчин, нөхцөлд тохируулан аюулгүй ажиллагааны хамгаалах тусгай хувцасны ерөнхий шаардлагад нийцүүлэн, батлагдсан эх загвар, ЗТББ-11 техникийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэнэ.

7.6.4.2 Загвар зохион бүтээлт болон хийцийн шаардлага

a) Хантаазан дээр дохиоллын элемент нь хэвтээ чиглэлд их биеийг бүтэн ороосон байдалтай байрлана.
b) Дохиоллын элемент нь 50 мм-ээс багагүй өргөнтэй; мөрөвч ба бүсний хувьд - 30 мм-ээс багагүй өргөнтэй байна.
c) Хантаазан дээр дараахь хувилбарын аль нэгд заасан дохиоллын элемент /тууз/ байрлуулсан байна. Үүнд:

- Их биений эргэн тойронд хоорондоо 50 мм-ээс багагүй зайд 2 хөндлөн тууз байх ба дээд талын туузыг энгэр, арын мөрөн дээгүүр дамнасан 2 босоо цацруулагч туузаар холбосон байх. Их биений доод тууз нь хантаазны хормойн ирмэгээс 50 мм-ээс багагүй зайд байх (А5 хавсралт. 1-3-р зураг).
- Их биений эргэн тойронд байх хөндлөн туузан цацруулагч материал нь 1 байж болох бөгөөд энэ нь ар, энгэрийн мөрөн дээгүүр дамнасан цацруулагч туузтай холбогдсон байх. Хэвтээ туузны доод ирмэг нь хантаазны доод ирмэгээс хамгийн багадаа 50 мм зайд байх (А5 хавсралт. 2-р зураг).

d) Хантаазны бүх өмсгөл хэмжээн дээр хажуу ташаа хэсэгт цацруулагч материал хоорондын зай нь 50 мм-ээс ихгүй байна.
e) Үндсэн материал болон цацруулагч, хосолсон материалтай хантаазны хувьд бэхэлгээний элемент ашиглах тохиолдолд түүний өргөн нь 50 мм-ээс ихгүй байна.
f) Хэрэв дохиоллын бүс бүхий мөрөвч хэрэглэх тохиолдолд бүс болон, мөрөвчин дээр дохиоллын элемент (тусгай эсвэл хосолсон материалан) байрлуулсан байна. Туузны өргөн нь 30 мм-ээс багагүй байна. Жич: Энэхүү стандартын шаардлагад нийцсэн бүстэй мөрөвч нь өндрөөс унахаас хамгаалахад зориулагдаагүй болно (А5 хавсралт. 4-5-р зураг).
g) Дохиоллын хантаазыг өвлийн, зуны аль ч ажлын тусгай хувцасны гадуур давхарлаж өмсөнө.

7.6.4.3 Хувцасны өмсгөл хэмжээ

a) Хувцасны өмсгөл хэмжээний ангилал нь энэхүү стандартын 7.2.1-д заасан ангилалтай тохирно.
b) Бэлэн бүтээгдэхүүний үндсэн хэмжээсүүдийг хэмжих байрлалууд, тэдгээрийн утгууд, хазайлтын хязгаарыг хувцасны загварын техникийн баримт бичигт тусгасан байна.

7.6.4.4 Техникийн шаардлагууд

a) Дохиоллын хантааз нь энэхүү стандартын 7.2.2-д заасан Техникийн шаардлагуудыг хангасан байна.
b) Хантаазны гадаад байдал нь ""МИАТ" ТӨХК-ийн ажилтнуудын ажлын тусгай зориулалтын хувцасны загвар"-ын альбомд тусгасан техникийн зургуудтай тохирч байна.
c) Хувцасны лого нь энэхүү стандартын 7.2.2.4-д заасан шаардлагуудад нийцнэ.

7.6.4.5 Нэмэлт шаардлагууд

Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага

a) Хантааз нь хүний эрүүл мэндэд хортой болон тааламжгүй нөлөө үзүүлэхээргүй хийцтэй, материалтай байна.
b) Дохиоллын хантааз нь ажилтныг өдөр тутам, өдрийн болон шөнийн гэрэлд ажил үүргээ гүйцэтгэх үед хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлын шаардлагын дагуу маш тод харагдах байдлыг хангасан байна.

Эргономикийн шаардлага

Эргономикийн хувьд дохиоллын хантааз нь дараах эргономикийн шаардлагыг хангаж байна. Үүнд:

a) Хантааз нь тусгай зориулалтын ажлын хувцасны гадуур давхарлаж өмсөхөд нэн тохирмжтой, тав тухтай байдлыг хангасан байна.
b) Хантаазны их бие болон бусад нэмэлт жижиг бүрдэл хэсгүүд нь ажилтны аливаа хөдөлгөөнд саад болохоргүй байна.
c) Хантаазыг өмсөөд ажил, үүргээ гүйцэтгэх үед осол гэмтлийн шалтгаан болох ёсгүй.

7.6.5 Хантаазны хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд

Дохиоллын хантаазны үйлдвэрлэл, хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд нь энэхүү стандартын:

- 7.2.4-д заасан "Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд тавих шаардлагууд",
- 7.2.5-д заасан "Хувцасны шошгонд тавигдах шаардлага",
- 7.2.6-д заасан "Хувцасны сав баглаа боодолд тавих шаардлага",
- 7.2.7-д заасан "Хувцсыг хүлээн авах, шалгахад тавигдах шаардлага"-ыг хангасан байна.

7.7 Хайлсан металлын шүршдэс, очноос хамгаалах тусгай хувцас. Техникийн шаардлагууд

7.7.1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь гагнуурын ажил гүйцэтгэх үед үүсэх үйлдвэрлэлийн хортой болон аюултай хүчин зүйлсээс ажиллагсдыг хамгаалахад зориулагдсан ажлын тусгай хувцсанд болон хүзүүний халхавчтай дотуур малгай, хормогч, түрий, ханцуйвч зэрэг хамгаалах хэрэгслүүдэд хамаарна.

Энэхүү стандартад нийцэх тусгай хувцас нь гагнуурын ажил гүйцэтгэх үед үүсэх үйлдвэрлэлийн хортой болон аюултай хүчин зүйлс: хайлсан металлаас үсэрсэн жижиг оч, металлын шүршдэс, галын дөлд богино хугацаанд хүрэлцэх үед, тогтмол гүйдлийн 100В хүртэлх хүчдэлтэй цахилгааны утаснаас цахилгаан гүйдэлд цохиулах эрсдлээс ажиллагсдыг хамгаалахад зориулагдсан болно.

7.7.2 Ангилал

Тусгай зориулалтын хувцсыг ашиглалтын нөхцөлөөс нь хамааран хамгаалах чадварын түвшнээр нь 3 ангид хуваана:

I анги – хайлсан металлын шүршдэс, үсэрсэн очны эх үүсвэрээс 2 м-ээс багагүй зайд өмсөхөд зориулагдсан хувцас. Энэ нь автомат гагнуурын шугам, аппаратан дээр ажиллах, металлыг механикаар таслах ажил юм;

II анги – хайлсан металлын шүршдэс, үсэрсэн очны эх үүсвэрээс 50 см орчим зайд өмсөж гараар гагнуур хийх үед өмсөхөд зориулагдсан хувцас. Энэ нь цехэд ажиллах, угсралтын болон хээрийн нөхцөлд хийх гагнуурын ажил юм;

III анги – хязгаарлагдмал багтаамж, талбайтай байранд хайлсан металлын шүршдэс, үсэрсэн очны эх үүсвэрээс 50 см орчим зайд гар гагнуур хийх үед өмсөхөд зориулагдсан хувцас. Энэ нь цистерн, төмөр хоолой гагнах, хийн гагнуураар металл таслах ажил юм.

7.7.3 Техникийн шаардлага

Тусгай зориулалтын энэхүү хослолыг энэхүү стандартын шаардлагад нийцүүлэн, хувцас үйлдвэрлэх технологийн дагуу, батлагдсан эх загвар, ЗТББ**-08** техникийн баримт бичгийн дагуу үйлдвэрлэнэ.

7.7.3.1 Нэр төрөл, өмсгөл хэмжээ

a) Тусгай хувцасыг дараах төрлүүдээр үйлдвэрлэнэ:
   - хослол – хүрэм ба өмд (А6 хавсралт, 1-р зураг) ;
   - иж бүрдэл – хослол ба нэмэлт эдлэл.

   Нэмэлт эдлэлүүдэд хүзүүний халхавчтай малгай, хормогч, ханцуйвч, бээлий (хоёр болон таван хуруутай), түрий орно.

b) Гагнуурын ажлын үед ажиллагчийн урд тал ба хажуу талыг хамгаалах зориулалттай хормогч (А6 хавсралт, 2-р зураг) хослол дээр давхарлан өмсөнө.

c) Хослолын өмсгөл хэмжээний ангилал нь энэхүү стандартын 7.2.1-д заасан ангилалтай тохирно.

d) Хормогчийг 7.23-р хүснэгтэд заасан 1, 2, 3 гэсэн гурван өмсгөл хэмжээгээр, өмсгөл хэмжээ бүр дотор 7.24-р хүснэгтэд заасан I, II, III чацаар үйлдвэрлэнэ.

7.23-р хүснэгт

Хормогчны өмсгөл хэмжээ	Өмсөх хүний өгзөгний бүслүүрийн хэмжээ, см
1	90-106
2	106-118
3	118-130

7.24-р хүснэгт

Хормогчны урт	Өмсөх хүний биеийн өндөр, см
I	146-164
II	164-176
III	176-188

e) Хувцасны зохион бүтээлтийн сулын хэмжээ нь хамгаалах түвшний ангиас хамаарч 7.25-р хүснэгтэд заасантай тохирч байна.

7.25-р хүснэгт

Хамгаалах шинж чанарын анги	Зохион бүтээлтийн сулын хэмжээ, см	
	хүрэм	өмд
	Цээжний бүслүүрийн хагаст	Бүсэлхийн бүслүүрийн хагаст
1	15,0	3,0
2	15,0	3,0-5,0
3	18,0	5,0

Тайлбар: Хувцасны зохион бүтээлтийн сулын хэмжээний утгад чөлөөт хөдөлгөөний болон материалын давхаргын зузааны сулын хэмжээ багтсан болно.

f) Дундаж өмсгөл хэмжээтэй бэлэн хослолын (хүрэм, өмд) үндсэн шугаман хэмжээсүүдийн утгууд нь бүтээгдэхүүний Техникийн баримт бичигт заасантай тохирч байна. Бэлэн хувцасны шугаман хэмжээсийн утгуудын байж болох хазайлтын хэмжээ нь:
- өргөний дагуух хэмжээсүүдэд - 1,0 см;
- уртын дагуух хэмжээсүүдэд - 1,5 см-аас хэтрэхгүй байна.

g) Хамгаалах хормогчны үндсэн хэмжээсүүд А6 хавсралт, 1-р хүснэгтэд заасантай тохирно.

7.7.3.2 Эргономикийн ба эдэлгээний шаардлагууд

Хувцас нь энэхүү стандартын 7.2.2-д заасан эргономикийн, эдэлгээний шаардлагуудыг хангасан байна.

7.7.3.3 Хийцийн элементүүдэд тавигдах шаардлага

7.7.3.3.1 Гагнуурчны хувцсыг дараах хийцийн шийдлүүдтэйгээр бэлтгэнэ:
a. Халаасны амсрын шугам нь ташааны оёдлоос 10°-аас ихгүй хазайлттай, бүсэлхийн шугамнаас доор байрлах энгэрийн хажуугийн халааснаас бусад халаасны гадна амсар нь тагтай байна;
b. Халаасны тагны урт нь амсрын шугамын уртаас 20 мм-аар илүү байна;
c. Халаасны тагийг халаасандаа сайн наалдсан байхаар тогтоосон байна;
d. Тагны хажуу ирмэгүүдийн дагуу дарж оёсон байж болно;
e. Өмдөнд нугалаас, эргэсэн манжет хийж болохгүй;
f. Товчлоосны элемент нь хайлсан металлын оч, дусал орж болох хэсгүүдэд нүх, нугалаас үүсэхээргүйгээр хийгдсэн байна;
g. Ханцуйны манжет нь товчлоостой байна. Товчлоос, түүнээс үүсэх нугалаас нь манжетны доод хэсэгт байрлана.

7.7.3.3.2. Ажил гүйцэтгэх үед (бөхийж, тонгойсон үед) хослолын хүрэм нь өмдний дээд хэсгийг 20 см-аас багагүй зайд хааж байна.

7.7.3.3.3 Хүрэм, өмдний товчлоос нь планк (хаалт), таг гэх мэт элементүүдээр хаагдаж байна. Товчны нүх хоорондын зай нь 15 см-аас ихгүй байна.

7.7.3.3.4 Өвдөглөж сууж ажилладаг тохиолдолд өмдний өвдөгний давхарлагыг зөөлөвч эсвэл, салдаг зөөлөвчтэй хийж болно.

7.7.3.3.5. Хамгаалах чадварын түвшингээр II ба III ангийн хувцсыг дараах шаардлагуудад нийцүүлэн бэлтгэнэ:
a. хүрэмний товчлоос далд байх бөгөөд баруун тал руу дарагдсан байна;
b. өмдөнд нугалаас, эргүүлж нугалсан хэсэг байж болохгүй. Өмдний товчлоос нь ташааны шугамдаа хийгдсэн байна;
c. хүрэмний ханцуйны хийц нь ажиллагчийн ажлын үндсэн хөдөлгөөнүүдийг гүйцэтгэх үеийн гарын байрлалд тохирсон байна;
d. хүрэмний ханцуйны үзүүрт галд тэсвэртэй материалаар сойлттой, дотор ханцуйвчтай байна;
e. энгэрт халаас нь бүсэлхийн шугамнаас доош босоо байрлах буюу ташааны шугамтай харьцуулахад 10°-аас ихгүй хазайсан байна;
f. хувцасны доорхи давхаргын бичил орчныг зохицуулах зорилготой нэмэлт салхивчтай байна.

g. Хамгаалах давхаргуудыг галд тэсвэртэй материалаар хийж, доор дурдсанаар байрлуулна:
- хүрэмний энгэр, хажуу оруулга, энгэрийн хөндлөн оруулга дээр;
- ханцуйны дээд хэсэгт 30 см-аас багагүй, үзүүрт 20 см-аас багагүй зайд;
- өмдний урд талд бүтэн (цамцны хормойны түвшнээс 10 см-аас багагүй дээр);
- өмдний ар талд шуумгаар 15 см-аас багагүй өндөртэй, ташааны болон алхмын шугамын дагуу15, см-аас багагүй урттай, өвдөгний шугамнаас дээш ба шуумаг хүртэл, 7 см-аас багагүй өргөнтэй.

7.7.3.3.6 Тодорхой үйлдвэрлэлийн хөдөлмөрийн нөхцлийн онцлогоос хамааран нэмэлт шаардлага оруулах тохиолдолд техникийн нөхцөлийн дагуу хувцсыг бэлтгэнэ.
Техникийн нөхцөлд энэ стандартын шаардлагуудаас бууруулсан шаардлага байж болохгүй.

7.7.4 Бэлтгэхэд тавигдах шаардлагууд

7.7.4.1. Хувцсыг энэхүү стандартын 7.2.4-д заасан “Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тавих шаардлагууд”-ад нийцүүлэн бэлтгэнэ.
7.7.4.2 Хувцасны гадна оёдлуудыг галд тэсвэртэй утсаар оёно. Ил оёдлуудыг хос оёогоор дарж оёсон байна. Дайлаас энгэр, захны давхарлага, ханцуйн дотор манжетыг галд тэсвэртэй материалаар (даавуу, сүлжмэл) хийнэ.

7.7.5 Материалд тавигдах шаардлагууд

7.7.5.1 Хайлсан металлын шүршдэс, очноос хамгаалах тусгай хувцсыг байгалийн ширхэгт бүхий, халуунд тэсвэртэй, амархан шатдаггүй, бөх бат (брезент), өндөр технологийн бусад ширхэгт бүхий даавуу материал, мөн илгэн арьс болон натураль савхиар үйлдвэрлэнэ.

7.7.5.2 Даавуу ба материалууд нь галд тэсвэртэй шинж чанартай байна.

7.7.5.3 Хамгаалах давхарлагууд нь (захиалагчийн зүгээс тусгай шаардлага тавиагүй бол) гадар давхаргын материалаар хийгдсэн байж болно.

7.7.5.4 Хайлсан металлын шүршдэс, үсэрсэн очноос хамгаалах хувцасны даавуу, материал нь хайлсан металлын шүршдэс, үсэрсэн оч тогтоохооргүй гадаргуутай байх бөгөөд өөрийн гадаргуу дээр хайлсан металлын шүршдэс, үсэрсэн оч хүрэлцсэнээс хойш 30 сек хугацаанд шатахгүй, уугихгүй байна.

7.7.5.5 Угаалга, химийн цэвэрлэгээний дараа даавууны хэмжээний өөрчлөлт суурь утасны дагуу 3,5 %, хөндлөн утасны дагуу 2,0 % хувиас хэтрэхгүй байна. Олсон ширхэгт агуулсан даавууны хэмжээний өөрчлөлт 5,0 % хувиас хэтрэхгүй.

7.7.5.6. Хүрэм, өмдний хослол, хормогчны материалын (галаас хамгаалах түрхлэгтэй брезент) физик-механик, эрүүл ахуйн болон хамгаалах шинж чанарын норматив үзүүлэлтүүдийг 7.26-р хүснэгтэд үзүүлэв.

7.7.5.7 Ашиглах материалуудын физик- механик шинж чанаруудын үзүүлэлтүүд дараах нэмэлт шаардлагуудад нийцнэ:
Гадаргуугийн нягт:
- **I** ангийн хувцсанд - 300 г/м^2 - 400 г/м^2 .
- **II, III** ангийн хувцсанд - 800 г/м$^{2-}$аас ихгүй.
I ангийн хувцсанд бөх батын дараах шинж чанартай материал ашиглаж болно. Үүнд:
- тасралтын даац - 800 Н-оос багагүй; - урагдалт тэсвэрлэлт- 50 Н-оос багагүй.

7.25-р хүснэгт

Материалын хамгаалах шинж чанарын норматив үзүүлэлтүүд

Материалын зориулалт	Гадаргуун нягт кг/м^2, ихгүй	Тасралтын даац, Н (кгх), багагүй		Урагдалт тэсвэрлэлт, Н (кгх), багагүй		Элэгдэлт тэсвэрлэлт, эргэлт, багагүй	Хөшүүн чанар, Н (кгх), ихгүй		Агаар нэвтрүүлэлт, дм (м·с)	Чийг шингээлт, %	Шаталт тэсвэрлэлт, сек, багагүй
		суурь	хөндлөн	суурь	хөндлөн		суурь	хөндлөн			
Хайлсан металлын шүршдэс, үсэрсэн очноос хамгаалах:											
- Агаарын өндөр хэмд	0,450	1000 (102)	900 (92)	70 (7,1)	60 (6,1)	500	0,1 (0,01)	0,1 (0,01)	30*-50	10-20	45**
- Цаг агаарын хэвийн нөхцөлд	0,550	1200 (122)	800 (82)	100 (10,2)	60 (6,1)	1000	0,3 (0,03)	0,3 (0,03)	20*-40	8-20	50**
- Хүйтэн нөхцөлд	0,600	1200 (122)	800 (82)	100 (10,2)	60 (6,1)	1500	0,5 (0,05)	0,5 (0,05)	8*-10	8-20	60**

*- Агаар нэвтрүүлэлтийн үзүүлэлтийн доод утгууд нь өвлийн хувцасны материалд тохирно.

**-Шаталт тэсвэрлэлтийн үзүүлэлтийн утга нь нэг давхарга даавуунд ба өнгө давхарга ба хамгаалах давхарлагаас бүрдсэн багцад тохирно.

7.7.5.8 Товч, цахилгаан товч зэрэг нь өндөр температур, индүүдлэг, химийн цэвэрлэгээнд тэсвэртэй байна.
7.7.6 Аюулгүй байдлын шаардлага

7.7.6.1 Хувцасны материал нь хүний биед хортой нөлөө үзүүлдэг хортой хольц агуулаагүй байна. Энэхүү шаардлагыг ажлын хувцас үйлдвэрлэхэд ашигласан материалын аюулгүй талаарх шинжилгээний хуудсаар баталгаажуулна.

7.7.7 Материал ба хувцасны туршилт

7.7.7.1 Материалын дээж авах ба хувцсыг туршилтад бэлтгэх

Материалын дээж авах
Туршилтад ашиглах дээжийг хамгаалах хувцсыг үйлдвэрлэхэд ашигладаг даавуу материал болон материалуудын багцаас авна. Бүх дээжийг аль болох хувцаснаас авна. Дээжний тоо, хэмжээ нь туршилтын аргын норматив техникийн баримт бичигт заасны дагуу байна.
Хувцасны гадар давхаргын материалыг туршилтад оруулна.

Хувцсыг туршилтад бэлтгэх

a) Ерөнхий зүйл
Хамгаалах хувцсыг туршихын өмнө урьдчилсан бэлтгэл буюу тогтворжуулалт хийнэ.

b) Цэвэрлэгээ
Хамгаалах хувцсыг туршихын өмнө арчилгааны зааврын дагуу цэвэрлэгээ хийгдсэн байна. Хэрэв цэвэрлэгээний тоог нэмэлтээр заагаагүй бол туршилт хийхийн өмнө 5 удаа цэвэрлэгээ хийгдсэн байна. 6.6, 6.11.2 ба 6.11.3-аар туршилтыг урьдчилсан бэлтгэлгүйгээр явуулна.

c) Хуучралт
Туршилтыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу аль болох олон тооны угаалга, цэвэрлэгээ хийсний дараа явуулна.

Лабораторийн нөхцөлд тогтворжуулах
Туршилт явуулахын өмнө бүх төрлийн материалуудын (савхинаас бусад) дээжүүдийг (20±2)°C агаарын хэмд, (65±5)% харьцангуй чийгшилтэй нөхцөлд 24 цагаас багагүй хугацаанд байлгана. Савхины дээж бол 48 цагийн хугацаанд байлгана.
Туршилтыг тогтворжуулалт хийгдсэн орчноос дээжүүдийг гаргаснаас хойш 5 мин-аас ихгүй хугацааны дараа эхлэх ёстой.

7.7.7.2 Туршилт хийх

Дөлний хязгаарлагдмал тархалт
Гагнуурчны хувцсанд ашигласан материалын төрөл тус бүр, оёдлын төрөл бүрийг ISO 15025-ын дагуу турших заавар А (кодлосон тэмдэглэгээ А1) эсвэл турших заавар В (кодлосон тэмдэглэгээ А2), эсвэл ажил гүйцэтгэх үед гардаг эрсдэлийн төрлөөс хамаарч дээрх 2 аргаар туршина.
Оёдлын туршилтыг ISO 15025-ын турших заавар А-ын дагуу оёо хийсэн 3 дээжин дээр хийнэ. Дээжний төв хэсэгт оёо нь хийгдсэн байх бөгөөд асаагуурын (горелка) галын дөлөөр шууд үйлчилнэ. Дөлд барьсны дараа оёдол бүтэн, гэмтээгүй байх ёстой.
Оёдлын туршилтыг ISO 15025-ын турших заавар В-ын дагуу ирмэгийг эмжсэн, оёо хийсэн 3 дээжин дээр хийнэ. Дээжний төв хэсэгт оёо нь хийгдсэн байх бөгөөд асаагуурын (горелка) галын дөлөөр шууд үйлчилнэ. Дөлд барьсны дараа оёдол бүтэн, гэмтээгүй байх ёстой.

Материалууд болон материалуудын багц нь дараахь шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

a) нэг ч дээжний хувьд дээд хэсэгт болон аль ч хажуу ирмэг дээр галын дөл тархсан байдал ажиглагдаагүй байх;

b) нэг ч дээж нэвт цоорч түлэгдээгүй байх;
c) нэг ч дээжин дээр шатсан хайлсан үлдэгдэл мөр үлдээгүй байх;

d) үлдэгдэл шаталтын хугацааны дундаж утга - 2 сек-ээс ихгүй;
e) үлдэгдэл уугилтын хугацааны дундаж утга - 2 сек-ээс ихгүй.

Хайлсан металлын шүршдэсний үйлчлэл
ISO 9150-ын дагуу турших үед материалууд болон материалуудын багц тус бүрийг:
- хайлсан металлын 15-аас багагүй дусал, туршиж байгаа I ангийн хувцасны эсвэл дээжний дотор талд 40°C байхаар датчикийн температурыг нэмэгдүүлэх;

- хайлсан металлын 25-аас багагүй дусал, туршиж байгаа II ангийн хувцасны эсвэл дээжний дотор талд 40°C байхаар датчикийн температурыг нэмэгдүүлэх.
Гал авалцсан материалыг туршилтыг даваагүй гэж үзнэ.

Дулааны цацрагийн үйлчлэл
ISO 6942-ын дагуу дулааны урсгалын нягт 20 кВт/м, дулааны цацрагийн индекс (24°C дэх RHTI) үед туршихад:
- I ангийн хувцсанд: RHTI24 7 сек-ээс багагүй;
- II ангийн хувцсанд: RHTI24 16 сек-ээс багагүй.

7.7.8 Хувцасны хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд
7.7.8.1 Гагнуурчны тусгай хувцасны хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд нь энэхүү стандартын:
- 7.2.4-д заасан “Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд тавих шаардлагууд”,
- 7.2.5-д заасан “Хувцасны шошгонд тавигдах шаардлага”,
- 7.2.6-д заасан “Хувцасны сав баглаа боодолд тавих шаардлага”,
- 7.2.7-д заасан ”Хувцсыг хүлээн авах, шалгахад тавигдах шаардлага”-ыг хангасан байна.

7.7.8.2 Гагнуурчны хувцас нь хамгаалах ангиас хамаарч дараах тэмдэглэгээ, пиктограммтай байна:
- I ангийн хувцас: энэхүү стандартын А6 хавсралт, 3-р зурагт үзүүлсэн пиктограмм, “Анги 1” тэмдэглэгээ, кодолсон тэмдэглэгээ- "А1", "А2" "А1 + А2";

- II ангийн хувцас: энэхүү стандартын дугаар, зураг 3-д үзүүлсэн пиктограмм, “Анги 2” тэмдэглэгээ, кодолсон тэмдэглэгээ- "А1", "А2" "А1 + А2";

7.7.9 Ашиглалтын зааварт тавигдах шаардлага
7.7.9.1 Ерөнхий зүйл
Энэхүү стандартад нийцсэн хувцсыг ашиглалтын заавартайгаар нийлүүлнэ**.** Ашиглалтын заавар нь MNS ISO 13688:2000-ын шаардлагад нийцсэн байна.

7.7.9.2 Ашиглалтын заавар дараах агуулгатай байна. Үүнд:
a) Хамгаалах хувцасны анги сонгох заавар
b) Хамгаалах эрсдэлийн төрөл
c) Шаардлагатай тохиолдолд өмсөж тайлах заавар
d) Ашиглалтанд тавих хязгаарлалт (өмсөх нормт хугацаа, ашиглалтын дараа устгах заавар г.м)
e) Хадгалах, арчлах заавар
f) Хувцасны материалын онцлогт тохирсон цэвэрлэгээний заавар (угаах горим, химийн цэвэрлэгээний бодис, индүүдэх температурын хязгаарлалт г.м)
g) Хувцасны хамгаалах чадварын цэвэрлэгээнд тэсвэртэй байдал

h) Хувцсыг зохих журмаар өмсөөгүй үедэх гарах эрсдлүүд

7.7.9.3 Хувцсыг зохих журмаар өмсөөгүй үедэх гарах эрсдлүүд

Ашиглалтын зааварт хувцсыг зохих журмаар өмсөөгүй үедэх гарах эрсдлүүдийн жагсаалтыг тусгасан байна.

a) хамгаалах хувцас нь амархан шатдаг бодисоор бохирдсоноор ил галаас хамгаалах чадвар нь буурна.
b) агаар дахь хүчилтөрөгчийн агууламж нэмэгдэх нь хамгаалах хувцасны ил галаас хамгаалах чадварыг бууруулна. Хязгаарлагдмал багтаамжтай орчинд гагнуурын ажил гүйцэтгэхдээ онцгой анхааралтай байх.
c) хамгаалах хувцас нь норсон болон бохирдсон үед түүний цахилгаан тусгаарлах чанар багасдаг тухай.
d) хоёр эдлэлээс бүрдсэн хамгаалах хувцасны ашиглалтын зааварт хоёр эдлэлийг хамтад нь өмссөн үед л заасан хамгаалах түвшин нь хангагдахыг заасан сануулгатай байх.
e) нэмэлт эдлэл ашиглах үед түүнийг зөвхөн үндсэн хамгаалах хослолд нэмэлтээр ашиглахыг анхааруулсан сануулгатай байх.

7.7.9.4 Арчилгааны заавар

Ашиглалтын заавар нь хамгаалах хувцасны угаалга, цэвэрлэгээний арга, угаалга, цэвэрлэгээний тооны хязгаар, засварлах заавар (зөвшөөрөгдөх тохиолдолд), зэргийг агуулсан байна.

Цэвэрлэгээний дараа хувцасны хамгаалах шинж чанар бүрэн хадгалагдсан эсэхэд үзлэг хийнэ.

8. Толгой хамгаалах хэрэгсэл. Техникийн шаардлага

8.1 Ангилал, гадаад байдал

8.1.1 “МИАТ” ТӨХК-ны ажилтны өмсөх толгой хамгаалах хэрэгслийг дараах байдлаар ангилна. Үүнд:

Зориулалтаар нь:

a) Хамгаалалтын дуулга
b) Хамгаалах давхарга
c) Өвлийн малгай (ушанка) (ТХХ-Ө-03)
d) Саравчтай дотортой өвлийн малгай (ТХХ-Ө-02)
e) Зуны саравчтай даавуун малгай (ТХХ-З-01)

Өмсөх улирлаар нь:

a) Дулааны улирлын
b) Хүйтний улирлын

8.1-р хүснэгт

Толгой хамгаалах хэрэгслийн нэр төрөл, зориулалт

д/д	Толгой хамгаалах хэрэгслийн нэр төрөл	Онцлог	Материал	Зориулалт
1	Өвлийн малгай /ушанка/ ТХХ-Ө-03 (Хавсралт А7 1-р зураг)	АХЗҮГ болон БХН-ийн ажилтнууд өмсөнө.	Гадар материал-нэхмэл материал Чих, цох, шилэвчний өнгө– хиймэл үс эсвэл флисс	Хүйтний улиралд гадна орчинд
2	Саравчтай дотортой өвлийн малгай ТХХ-Ө-02	ГҮАЕМХХН-ны ажилтнууд өмсөнө.	Гадар материал-нэхмэл материал Дотрын материал – дулааны шаардлага	Хүйтний улиралд гадна орчинд

	(Хавсралт А7 2-р зураг)		хангасан бусад материал (флисс)	
3	Хамгаалалтын дуулга малгай (Хавсралт А7 3-р зураг)	Толгой хамгаалах дуулга, нэмэлт хэрэгсэлтэй дуулга малгай	Polyethelene-PE Polycarbonate-PC	Толгой дээр биет унах, нүүр, нүд, сонсгол гэмтэх эрсдэлтэй орчинд
4	Хамгаалах давхарга (Хавсралт А7 4-р зураг)	Малгайн дотор өмсөх хамгаалах давхарга /ажлын нөхцлөөс хамаарч ямар ч улирлын малгайны дотор өмсөж болно/	polyethelene-PE acrylonitrile butadiene styrene -ABS	Хатуу зүйл мөргөж толгой гэмтэх эрсдэлтэй орчинд
5	Зуны саравчтай малгай ТХХ-З-01 (Хавсралт А7 5-р зураг)	60 мм-ээс бага хэмжээтэй саравчтай малгай	Нэхмэл материал	Дулааны улиралд гадна болон дотор орчинд

8.1.2 Хамгаалалтын дуулгыг:

a) толгой хамгаалах дуулга,
b) нэмэлт хамгаалах хэрэгсэлтэй дуулга гэж ангилна.

8.1.3 Гадаад байдал

a) Дулаан улиралд өмсөх малгай нь хөдөлмөрийн аюулгүй байдалд нийцсэн саравчтай эсвэл саравчгүй нэхмэл материалтай малгай байна.
b) Өвлийн малгай жижиг саравчтай эсвэл үслэг цохтой байна.
c) Тухайн нэгжийн ажилтны өмсөх малгайны өнгө нь ажлын тусгай үндсэн хувцасных нь өнгөтэй ижил байна.
d) Малгайны технологи боловсруулалт нь зохих технологийн шаардлага хангасан, гадаад үзэмж нь чанарын шаардлага хангасан байна. Эмблем, тэмдэглэгээ нь тогтсон хэмжээ, байрлалтай байна.
e) Бэлэн малгайны гадаад байдал, хэмжээ, чанар нь энэхүү стандартын шаардлагад нийцсэн байна.
f) Малгайны нэр төрлүүдийн гадаад байдлыг А7 хавсралтын1-5-р зурагт, бэлэн бүтээгдэхүүнийг хэмжих байрлалыг 6-8-р зургуудад үзүүлэв.
g) Бэлэн бүтээгдэхүүний хэмжилтийн хазайлт нь А7 хавсралтын 1-р хүснэгтийн үзүүлэлттэй нийцэж байна.

8.2 Техникийн шаардлагууд

8.2.1 Хамгаалалтын дуулга малгайд тавих шаардлага

8.2.1.1 Ажилтны хамгаалалтын дуулга нь толгой дээр гадны биет унахад толгойг хамгаалах зориулаттай бөгөөд MNS 5621:2006 стандартын шаардлага хангасан байна.
Дуулгыг стандартад нийцүүлэн ММ - механик үйлчлэл 400-1000 VAC цахилгаан хүчдэл, -50^{0}C...+150 температур, LD-гэрлийн нөлөөллөөс толгойг найдвартай хамгаалах чадвартай polyethelene- PE, polycarbonat – PC материалаар хийсэн байна.

8.2.1.2 Сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь 85 дБ-с дээш шуугианыг найдвартай бууруулж, чихэвч нь хүний чихэнд сөрөг нөлөөгүй байна.

8.2.1.3 Нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалан тунгалаг (салхины хүч нь 12-190м/с/, гэрлийн бууралт /0-11DIN бууруулах)-тай ба өнгө үзэмжтэй, нүдийг гадны биетээс найдвартай хамгаалсан байна.

8.2.1.4 Нүүрийг өөрийн техникийн үзүүлэлтийн хүрээнд хүний эрүүл мэндэд сөрөг хор нөлөөгүйгээр хамгаалсан байна.

8.2.1.5 Хамгаалалтын дуулга малгай нь механик үйлчлэлийн үед найдвартай хамгаалах чадвартай байна.

8.2.2 Хамгаалах давхаргад тавих шаардлага

8.2.2.1 Хамгаалах давхарга нь тархи гавлын гэмтэл учруулах хөдөлгөөнтэй унаж болзошгүй биетээс хамгаалахгүй тул хамгаалалтын дуулга малгайны оронд хэрэглэхгүй.

8.2.2.2 Хамгаалах давхарга нь цохилтын энергийг шингээх хэрэгсэлтэй байна. Малгай нь ажилтны биед гэмтэл учруулах хурц ирмэг, өнцөггүй хийцтэй байна. Малгайг өмсөх тохируулгыг хийхэд хялбар байх шаардлагатай.

8.2.2.3 Хамгаалах давхаргын агааржуулалтын нүхний хэмжээ 150-450 мм^2 хэмжээтэй байна.

8.2.3 Материалд тавих шаардлага

8.2.3.1 Малгайнд ашиглах материалууд нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

8.2.3.2 Малгайны материалын будгийн тогтоц хими цэвэрлэгээ, хөлс, үрэлтэнд бат бөх байна.

8.2.3.3 Хамгаалах давхарга нь эдэлгээний болон чанарын үзүүлэлтүүдийг хангасан, эдэлгээний явц/шороо тоос, доргилт, хөлс, гоо сайхны бүтээгдэхүүний үйлчлэл,цаг агаарын нөхцөл/-д илт өөрчлөгдөхгүй полимер материал байна.

8.2.3.4 Хүйтний улирлын чихтэй малгай (ушанка)-ны орой, дотор чих, цох, шилэвчийг нэхмэл материалаар; гадар чих, цох, шилэвчийг жинхэнэ ба хиймэл үсээр; эсвэл флисс материалаар болон бусад төрлийн дулааны шаардлага хангасан материалаар хийнэ.

8.2.3.5 Хүйтний улирлын чихтэй малгай /ушанка/-ны дотрыг дулаалгатайгаар эсвэл флисс материалаар бэлтгэнэ.

8.2.3.6 Хүйтний улирлын саравчтай малгайны гадар нь нэхмэл материалаар, дотрыг флисс материалаар болон бусад төрлийн дулааны шаардлага хангасан материалаар хийнэ.

8.2.3.7 Дулаан улирлын малгайны материал цаг агаарын нөхцөлд тохиромжтой, хөлс чийгийг сайн шингээдэг, эдэлгээний хугацааг даах, сайн угаагдах шинж чанартай 30% -иас багагүй хөвөн ширхэгт агуулсан нэхмэл материал байна. Энэ төрлийн малгайны агааржуулалтын нүх, хамгаалах давхаргын агааржуулалтын нүхтэй ижил байрлалд байна.

8.2.4 Үйлдвэрлэлийн явцад тавих шаардлага

a) Оёмол малгай, түүний бүрдэл хэсгийн гадаад байдлыг сайжруулах, хэлбэрийг хадгалахын тулд наалт нааж хатуулан бэлтгэж болно.
b) Доторгүй малгайны ирмэгүүдийг хэрсэн эсвэл эмжсэн байна.
c) Нэгтгэх оёдлуудад 1 см дах хатгацын тоо 4-5, ил оёдлуудад загварт заасан хэмжээгээр байна.
d) Оёдлын мөр жигд тэгшхэн, ирмэгээс оёдол хүртлэх зай эхнээсээ төгсгөл хүртэл ижил зайтай байна.
e) Оёдол нь үрчийгээгүй, татагдаагүй, мөлгөр зөөлөн байна.

f) Оёдлын төрөл нь даавууны шинж чанар болон зориулалтад тохирсон байна.
g) Оёдлын өргөн нь оёоны төрөл, хувцасны дизайнд зохицсон байна.
h) Малгайн цох, чихний ирмэг нь ямар нэгэн нугалаас, хуниас, үрчлээгүй, тэгш, зөөлөн байна.
i) Малгайны ирмэгийн боловсруулалт нь хувцасны хэв маяг, даавууны төрөлд тохирсон байна.
j) Малгайны ирмэгийн дагуух ил оёдлыг тохирсон утсаар, заасан хатгацын урттайгаар жигд оёсон байна.
k) Ирмэгийг хэрсэн оёдол нь зөөлөн, сэмэрсэн сул унжсан утасгүй байна.

8.2.5Эдэлгээний шаардлагууд

a) Малгай нь нормт хугацааны туршид өөрийн шинж чанараа хадгалах, эдэлгээнд найдвартай (хэлбэрээ хадгалалт, элэгдэлт тэсвэрлэлт сайтай), засварлах боломжтой байна.
b) Ашиглалтын явцад малгайны материал, оёсон оёдол нь урагдахгүй, нэхээс нь хөврөхгүй, үс нь унахгүй, элэгдэл болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг тэсвэрлэх чадвартай байна.

8.2.6 Толгой хамгаалах хэрэгслийн хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд нь энэхүү стандартын 7.2-д заасантай тохирно.

8.2.7 Оёмол малгайн хаяглалт, шошгололт, сав баглаа боодол, хүлээн авах шалгахад тавигдах шаардлагууд нь энэхүү стандартын:
- 7.2.5-д заасан “Хувцасны шошгонд тавигдах шаардлага”,
- 7.2.6-д заасан “Хувцасны сав баглаа боодолд тавих шаардлага”,
- 7.2.7-д заасан ”Хувцсыг хүлээн авах, шалгахад тавигдах шаардлага”-ыг хангасан байна.

8.2.8 Шошгонд тавих нэмэлт шаардлага

a) Малгайны шошгонд дараах нэмэлт шаардлага тавигдана.
   - Шошго нь малгайны ар шилний хэсэгт хадагдсан байна.
   - Шошго нь сайн харагдах, уншигдах боломжтой байна

b) Шошгоны нэмэлт мэдээлэл
Хамгаалах давхаргын шошгон дээр “Анхаар - хамгаалалтын дуулга малгайны оронд өмсөж болохгүй” гэж монгол хэл дээр бичиж анхааруулсан байна.

9. Хөл хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага

9.1 Гутлын ангилал, загвар
“МИАТ” ТӨХК-ний ажилтны ажлын тусгай гутлыг дараах байдлаар ангилна. Үүнд:

Зориулалтаар нь:
a) Механик биетээс хамгаалах;
b) Ус чийгнээс хамгаалах;
c) Химийн бодисоос хамгаалах;
d) Онцгой нөхцөлд өмсөх.

Ажлын байрны орчноор нь:
a) Гадна;
b) Дотор.

Материалын нэр төрлөөр нь:
a) Савхин материал;
b) Резинэн болон полимер.

Гутлын нэр төрлөөр нь:
a) Хагас түрийтэй ботинк (Зураг 9.1а);
b) Ботинк (Зураг 9.1б);

c) Хагас түрийтэй гутал (Зураг 9.1в); *(Жич: гутлын түрийний өндрийг хэрэглэгчдийн захиалгаар уртасгаж, богиносгож болно)*

d) Усны гутал.

а. б. в.

9.1-р зураг. Гутлын нэр төрөл

Ажлын тусгай гутлын бүтцийн зургийг А8 хавсралтад үзүүлэв.

Хүйсээр нь:

1. Эрэгтэй
2. Эмэгтэй

Улирлаар нь:

1. Дулааны
2. Хүйтний

Хийц зохиомжоор нь:

1. Үдээстэй гутал
2. Үдээсгүй гутал гэж ангилна.

9.2 Гутлын өмсгөл хэмжээ

Гутлын өмсгөл хэмжээнд тохирох хөлийн тавхайн уртын хэмжээг 9.1-р хүснэгтэд үзүүлэв.

9.1-р хүснэгт

Гутлын өмсгөл хэмжээ ба тавхайн урт

Гутлын өмсгөл хэмжээ	Хөлийн тавхайн урт, см	
	Эрэгтэй ажилтан	Эмэгтэй ажилтан
35	-	22,8
36	-	23,5
37	-	23,8
38	24,1	24,5
39	24,4	25,1
40	24,8	25,4
41	25,7	26,0
42	26,0	-
43	27,0	-
44	27,3	-
45	28,3	-
46	28,6	-

Гутлын өмсгөл хэмжээ 9.2-р хүснэгтэд заасантай тохирно.

9.2-р хүснэгт

Гутлын өмсгөл хэмжээ

Хүйс	Тэмдэг лэгээ	Өмсгөл хэмжээ													
Эмэгтэй хүний	Метрийн, мм	215	220	225	230	235	240	245	250	255	260	265	270		
	Метрийн, см	22 1/	23	23 1/2	24	24 1/	25	25 1/	26	26 1/	27	27 1/	28		
	Францын, штих	34	35	36	37	37 1/	38	38 1/	39	40	41	41 1/	42		
Эрэгтэй хүний	Метрийн, мм	240	245	250	255	260	265	270	275	280	285	290	295	300	305
	Метрийн, см	25	25 1/	26	26 1/	27	27 1/	28	28 1/	29	29 1/2	30	30 1/2	31	31 1/
	Францын, штих	38	38 1/	39	40	41	41 1/	42	42 1/	43	44	45	46	47	47 1/

9.3 Техникийн шаардлагууд

Ажлын тусгай гутал нь дараах техникийн шаардлагуудыг хангасан байна.

9.3.1 Үйлдвэрлэгч нь гутлын технологийн заавар, техникийн бусад баримт бичгийг боловсруулж захиалагчаар батлуулна.

9.3.2 Ажлын тусгай гутлын түрийний өндрийн хэмжээ EN ISO20345:2004-д заасантай тохирч байна (9.3-р хүснэгт).

9.3-р хүснэгт

Гутлын түрийний өндрийн хэмжээ

Өмсгөл хэмжээ		Өндөр		
Франц, штих	Метрийн систем, мм	Хагас түрийтэй ботинк, мм-ээс дээшгүй	Ботинк, мм-ээс доошгүй	Хагас түрийтэй гутал, мм
36-аас доош	225-аас доош	<103	>103	162-оос 255 хүртэл
37-38	235-240	<105	>105	165-аас 260 хүртэл
39-40	250-255	<109	>109	172-оос 270 хүртэл
41-42	265-275	<113	>113	178-аас 280 хүртэл
43-44	285-290	<117	>117	185-аас 290 хүртэл
45-аас дээш	295-аас дээш	<121	>121	192-оос 300 хүртэл

9.3.3 Ажлын тусгай гутал (өрөөсөн)-ын жин 990 граммаас хэтрэхгүй байна.

9.3.4 Ботинк болон хагас түрийтэй үдээстэй гутал нь битүү хэлтэй байна. Хагас түрийтэй үдээсгүй гутлын түрий нь өргөсгөх, нарийсгах зориулалтын нэмэлт эд ангитай байж болно (А8 хавсралт, 4-р зураг).

9.3.5 Ажлын гутлын металл хамрын хатуулгад EN ISO20345:2004, 5.3.2.5.1-д заасны дагуу зэврэлттэй гадаргуу 5-аас илүүгүй байх ба гадаргуу дахь зэвийн хэмжээ нь 2.5 мм^2-аас хэтрэхгүй байна.

9.3.6 Ажлын гутлын металл биш хамрын хатуулга нь EN ISO20345:2004, 5.3.2.5.2-д заасан шаардлагыг хангасан химийн болон дулааны үйлчлэлийг эсэргүүцэх чадвартай байна.

9.3.7 Ажлын гутлын гадуур ул нь ISO 20880:2007 стандартад заасны дагуу керамик шал болон нойтон гадаргуун дээр халтиргаанд тэсвэрлэх чадвар өсгийн хэсэгт 0.30, улны гадаргууд 0.28 –аас ихгүй байна.

9.3.8 Ажлын тусгай гутлын халуунд тэсвэрлэх чадвар нь EN ISO20345:2004, 6.4.4 заалтын дагуу резинэн болон полимер гадуур ул хайлахгүй, нугаралтанд хагарахгүй байна.

9.3.9 Ажлын гутлын өсгийн энерги шингээх чадвар нь EN ISO 20345:2004, 6.2.4 заасны дагуу 20 Ж–аас багагүй байна.
9.3.10 Ажлын гутлын түрийнд цацруулагч буюу харанхуйд гэрэл ойлгогч хийсэн байна.
9.3.11 Ажлын тусгай гутлын түрийний өнгө болон дотрын зориулалттай боловсруулсан арьс, үслэг нэхийний хими, физик-механикийн үзүүлэлтүүд 9.4-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

9.4-р хүснэгт

Ажлын тусгай гутлын түрийний өнгө болон дотрын зориулалттай боловсруулсан арьс, үслэг нэхийний хими, физик-механикийн үзүүлэлтүүд

д/д	Үзүүлэлт	Хром, нубук	Юфть	Шевро	Дотрын зориулалттай арьс	Үслэг нэхий
1	Чийг, %	14				16
2	Тос, %	5-10	5,5-12	6-14	5-10	5-12
3	Оксид хром, % доошгүй	3,5				2-3
4	Тасралтын даац, Н/мм^2, доошгүй	25	25	18	12	-
5	Өнгөний язралт, Н/мм^2, доошгүй	15	15	12	8	-
6	Харьцангуй суналт, %, доошгүй	15	15	15	18	25-аас ихгүй
7	Будгийн тогтвор үрэлтэд, оноо, доошгүй - хуурай /20/ - нойтон /10/	4-5 3-5	4-5 3-5	4-5 3-5	5	4 5
8	Хучих будгийн олон нугаралт тэсвэрлэх чадвар, удаа, доошгүй	3000	2000	3000	-	-
9	Ус нэвтрэлт, гр/цаг	0,5	0,35	0,5	-	-
10	Үлдэгдэл суналт, %, талбайгаар	5-15	5-12	10-20	-	-
11	Арьсны зузаан, мм	1,4-2,0	1,7-2,4	0,7-1,3	0,6-1,2	1-1,2

9.3.12 Ажлын гутлын улны давхаргын дулаан тусгаарлах чадвар нь EN ISO 20345:2004, 6.2.3.1-д заасны дагуу температур нэмэгдэхэд дотуур улны гадаргуу 22^{0}С-ээс ихгүй байна.
9.3.13 Ажлын гутлын улны давхаргын хүйтэн тусгаарлах чадвар нь EN ISO 20345:2004, 6.2.3.2-д заасны дагуу температур буурахад дотуур улны гадаргуу 10^{0}С-ээс багагүй байна.
9.3.14 Гутлын ус нэвтрэлтийн үзүүлэлтийн доод хэмжээ MNS 0078:1988 стандартын 2.7-д заасан үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна.
9.3.15 Гутлын уян нугарамхайшлийн үзүүлэлт нь 9.5-р хүснэгтэд заасан шаардлагатай тохирч байх ёстой.

9.5-р хүснэгт

Гутлын уян нугарамхайшлын үзүүлэлт

Гутлын төрөл	Улалгааны арга	Уян нугарамхайшил кгх /см-ээс доошгүй			
		Улны шир	Шахмал резин	Хөвсгөр резин	Шахмал шир
Эрэгтэй хүний	Наалт	1,5	-	1,2	1,2
	Халааж боловсруулах	-	1,3	1,2	-
	Даралтаар цутгах	-	1,5	-	-
Эмэгтэй хүний	Наалт	1,1	1,1	1,0	-
	Халааж боловсруулах, даралтаар цутгах	-	1,0	0,9	-

9.3.16 Ажлын тусгай гутлын түрийний оёоны бөх батын үзүүлэлт нь 9.6-р хүснэгтэд заасан шаардлагатай тохирно.

9.6-р хүснэгт

Ажлын тусгай гутлын түрийний оёоны бөх батын үзүүлэлт

Материалын нэр	Үзүүлэлтийн доод хэмжээ, Н/см		
	Дан оёонд	Давхар оёонд	Хоёроос дээш оёонд
Бүх төрлийн хром, бухаар, булигаар, бүх төрлийн даавуу	75,0	100,0	120,0

9.3.17 Ажлын гутлын улалгааны бөх батын үзүүлэлт нь MNS 0078:1988 стандартын 4.8-д заасан үзүүлэлттэй тохирч байна.
9.3.18 Онцгой нөхцөлд өмсөх гутал нь EN ISO20345:2004 стандартад заасан S1, S2, S3 ангиллын шаардлага хангасан байна (9.7-р хүснэгт).
9.3.19 Усны гутал нь EN ISO20345:2004 стандартын S4, S5 ангиллын шаардлага хангасан байна (9.7-р хүснэгт).

9.7-р хүснэгт

Онцгой нөхцөлд өмсөх гуталд тавигдах шаардлага

Ангилал	Материалын нэр төрөл	Шаардлага	Таних тэмдэг
S1	Савхин	Уян хатан байх Халтирахаас хамгаалах Механик биетээс хамгаалах (200Дж) Химийн бодисоос хамгаалах Цахилгаанаас хамгаалах	
S2	Савхин	S1+ Ус чийгээс хамгаалах	
S3	Савхин	S2+Механик биетийн нэвтрэлтээс хамгаалах	
S4	Резинэн болон полимер	Уян хатан байх Халтирахаас хамгаалах Механик биетээс хамгаалах (200Дж) Химийн бодисоос хамгаалах Цахилгаанаас хамгаалах Ус чийгээс хамгаалах	
S5	Резинэн болон полимер	S4+Механик биетийн нэвтрэлтээс хамгаалах	

9.3.20 Ажлын тусгай гутлын эдэлгээний хугацааг тогтоох, захиалга, хангамжийн ажлыг зохион байгуулах, хяналт тавих үйл ажиллагааг байгууллагад мөрдөгддөг журмаар зохицуулна.

9.4 Хаяглах, савлах, хадгалах, тээвэрлэхэд тавих шаардлага

Хөл хамгаалах хэрэгслийн хаяглах, савлах, хадгалах, тээвэрлэхэд тавих шаардлага нь энэхүү стандартын 6.3, 6.4-д заасантай тохирно.

9.5 Сорилт, туршилтын арга

Гутлаас лабораторийн сорилт туршилтад дээж авахад MNS0176:1988 Гутал, Лабораторийн сорилт туршилтын аргууд стандартад заасны дагуу парт тутмаас 0,05 хүртэл хувиар бодож дээж авна. Гэхдээ дээжний тоо 1 хосоос цөөнгүй байна.

ТӨГСӨВ.

А1 ХАВСРАЛТ

(норматив)

Хувцасны өмсгөл хэмжээ тодорхойлоход шаардлагатай биеийн үндсэн хэмжээсний байрлал



1-р зураг. Хүний биеэс авах үндсэн хэмжээсүүд



2-р зураг. Сарвууны бүслүүр



3-р зураг. Хөлийн тавхайн урт

1-р хүснэгт

Хүний биеэс хэмжээ авах арга

№	Биеийн хэмжээсийн нэр	Тодорхойлолт
1	Биеийн өндөр	цэх зогсож байгаа хүний тавхайнаас толгойн оройн цэг хүртэл хэмжсэн хэмжээс

2	Толгойн бүслүүр	духны болон дагзны төвгөрүүдийг дайруулан бүсэлж хэмжсэн хэмжээс
3	Хүзүүний бүслүүр	хүний хүзүүнд жигд шүргүүлэн угаар нь бүсэлж хэмжсэн хэмж
4	Цээжний бүслүүр	хөхний товчийг дайруулан хэвтээ чиглэлд бүсэлж хэмжсэн хэмжээс
5	Бүсэлхийн бүслүүр	цээжин биеийн нарийссан хэсэг болох бэлхүүсийг бүсэлж хэмжсэн хэмжээс
6	Өгзөгний бүслүүр	өгзөгний төвгөр цэгийн түвшингээр өгзөгийг бүсэлж хэмжсэн хэмжээс
7	Хөлийн тавхайн урт	өсгийн арын цэгээс хөлийн хамгийн урт хурууны үзүүрийн цэг хүртэл хэмжсэн хэмжээс
8	Сарвууны бүслүүр	эрхий хуруу долоовор хуруунаас салган бусад хуруунуудад перпендикуляр чиглэлд сарвууг бүсэлж хэмжсэн хэмжээс
9	Гарын урт	мөрний цэгээс гарын шууны доод цэг хүртэл уртыг хэмжсэн хэмжээс

А2 ХАВСРАЛТ

Хавар-намрын болон өвлийн тусгай хувцас

1-р хүснэгт

Өвлийн хувцасны зохион бүтээлтийн сулын хэмжээсийн утга

№	Хувцасны төрөл	Зохион бүтээлтийн хэрчим	Зохион бүтээлтийн сулын хэмжээ*, см
1	Хавар-намрын хүрэм	Цээжний бүслүүр	21.0-18.0
2	Хавар-намрын өмд	Бүсэлхийн бүслүүр	3.0-5.0
3	Өвлийн хүрэм	Цээжний бүслүүр	21.0-24.0
4	Өвлийн өмд	Бүсэлхийн бүслүүр	5.0-7.0

ТАЙЛБАР: Сулын хэмжээ нь чөлөөт хөдөлгөөний сулын хэмжээ ба давхаргын зузааны сулын хэмжээний нийлбэртэй тэнцүү.*

А3 ХАВСРАЛТ

Зуны тусгай хувцас. Техникийн шаардлагууд

1-р хүснэгт

Эрэгтэй ажилтны тусгай хувцасны зохион бүтээлтийн сулын хэмжээ

	Зохион бүтээлтийн сулын хэмжээ, см		
	Мөрний хэсгийн хувцас	Бүсэлхий хэсгийн хувцас	Мөр бүсэлхийн хувцас

Тусгай зориулалтын хувцас	Цээжний бүслүүрийн хагаст	Бүсэлхийн бүслүүрийн хагаст	Цээжний бүслүүрийн хагас	Бүсэлхийн бүслүүрийн хагас
Үйлдвэрлэлийн бохирдлоос хамгаалах	9-12	2-3	12	3
Механик үйлчлэлээс хамгаалах	12-15	2-3	12-15	3-5
Тайлбар 1. Зохион бүтээлийн оновчтой сулын хэмжээг ашиглах материалын төрөл, физиологи, эрүүл ахуй шинж, ажил гүйцэтгэх явцад хүний энерги зарцуулалт зэргийг харгалзан тогтоож өгнө. 2. Хэрэглэгчийн хүсэлтээр ажлын хувцасны зориулалтаас хамааран зохион бүтээлтийн сулын хэмжээг нэмэж, бууруулж болно.				

2-р хүснэгт

Эмэгтэй ажилтны тусгай хувцасны зохион бүтээлтийн сулын хэмжээ

Тусгай зориулалтын хувцас	Зохион бүтээлтийн сулын хэмжээ, см			
	Мөрний хэсгийн хувцас	Бүсэлхий хэсгийн хувцас	Мөр бүсэлхийн хувцас	
	Цээжний бүслүүрийн хагас	Бүсэлхийн бүслүүрийн хагас	Цээжний бүслүүрийн хагас	Бүсэлхийн бүслүүрийн хагас
Үйлдвэрлэлийн бохирдлоос хамгаалах	9-12	2	12	2
Механик үйлчлэлээс хамгаалах	12-15	2-4	12-15	2-4
Тайлбар 1. Зохион бүтээлийн оновчтой сулын хэмжээг ашиглах материалын төрөл, физиологи, эрүүл ахуй шинж, ажил гүйцэтгэх явцад хүний энерги зарцуулалт зэргийг харгалзан тогтоож өгнө. 2. Хэрэглэгчийн хүсэлтээр ажлын хувцасны зориулалтаас хамааран зохион бүтээлтийн сулын хэмжээг нэмэж, бууруулж болно.				

А4 ХАВСРАЛТ

1-р хүснэгт

Гэрэл цацруулагч туузанд тавих шаардлага

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн утга
1	Суурь материалын ширхэгтийн бүрэлдэхүүн, %	Полиэстр 100%
2	Гэрэл ойлголтын коэффициент, кд/люкс*м^2, багагүй: - Шинэдээ	330 300

	- 25 угаалтын дараа - 5000 эргэлт үрэлтийн дараа	300
3	Угаалт тэсвэрлэлт (60°C температурт), эргэлт, багагүй	25
4	Элэгдэлт тэсвэрлэлт**, эргэлт, багагүй:	5000

B4 ХАВСРАЛТ

(Мэдээллийн)

Зуны тусгай хувцас

Зуны хувцасны хамгаалах шинж чанарын тэмдэглэгээ (Пиктограмм)

Тэмдэглэгээ	Зориулалт
 **Мү**	Механик үйлчлэлээс хамгаалах
Мэмү	Механизмын хөдөлгөөнт хэсгүүдийн механик үйлчлэлээс хамгаалах
 **Мзцү**	Зүсэх, цоолох механик үйлчлэлээс хамгаалах

А5 ХАВСРАЛТ

Дохиоллын хантааз



Зураг 1. Хантаазан дээрхи цацруулагчийн байрлал. Загвар-1



Зураг 2. Хантаазан дээрхи цацруулагчийн байрлал. Загвар-2



Зураг 3. Хантаазан дээрхи цацруулагчийн байрлал. Загвар-3

А5 ХАВСРАЛТ



Зураг 4. Дохиоллын мөрөвч ба бүс-1



Зураг 5. Дохиоллын мөрөвч ба бүс-2

А5 ХАВСРАЛТ



Зураг 7. “МИАТ” ТӨХК-ийн дохиоллын хантааз. Загвар 1

А5 ХАВСРАЛТ



Зураг 8. “МИАТ” ТӨХК-ийн дохиоллын хантааз. Загвар 2

А5 ХАВСРАЛТ



Зураг 9. “МИАТ” ТӨХК-ийн дохиоллын хантааз. Загвар 3

B5 ХАВСРАЛТ

Дохиоллын хантааз

Пиктограмм



Зураг 1. X - хантаазны ангилал; Y - цацруулагч материалын ангилал

Пиктограмм дээрх эхний тоо нь хүснэгт 1-н дагуу материалын хэмжээгээр хувцасны ангиллыг заана, хоёр дахь тоо нь хүснэгт 5 эсвэл 6-н дагуу цацруулагч материалын ангиллыг заана.

A6 ХАВСРАЛТ
Хайлсан металлын шүршдэс, очноос хамгаалах тусгай хувцас

1-р зураг. Гагнуурчны хослолын гадаад байдал

1-р хүснэгт

Гагнуурчны хормогчны үндсэн хэмжээсүүд

2-р зураг дээрх хэмжилтийн дугаар	Хэмжилтийн нэр	Чац	Өмсгөл хэмжээ			Байж болох хазайлт
			1	2	3	
1	Энгэрийн урт	I II III	90,0 100,0 110,0	90,0 100,0 110,0	90,0 100,0 110,0	±1,0
3	Цээживчний дээд хэсгийн өргөн	-	26,0	28,0	30,0	±0,5
5	Хажуугийн дээд булангийн түвшин дэх өргөн	-	54,0	58,0	62,0	±1,0
6	Хормойн өргөн:	-	76,0	80,0	84,0	±1,0



а



б

2-р зураг. Гагнуурчны брезентэн хормогч:

а- гадаад байдал; б- бүтээгдэхүүнд хэмжилт хийх хэсгүүд.

Зураг 3. Гагнуурын ажлын үе дэх эрсдлээс хамгаалах пиктограмм
(ISO 7000-2683)

А7 ХАВСРАЛТ
Толгой хамгаалах хэрэгсэл

1-р зураг. Хүйтний улирлын чихтэй малгай (ушанка). Бүрдэл хэсгүүд:

1- цох; 2- малгайны орой; 3- чих; 4- шилэвч.



2-р зураг. Хүйтний улирлын саравчтай малгай. Бүрдэл хэсгүүд:

1- малгайны орой; 2- саравч; 3- чих.



3-р зураг. Хамгаалалтын дуулга малгай. Эд ангиуд:

1- саравч ; 2- агааржуулалтын нүх; 3- толгойн оройноос хөндийрүүлэх татуурга;

4- бэхлэвч; 5- хөлс шингээгч жийргэвч.



4-р зураг. Хамгаалах давхарга. Эд ангиуд:

1- хамгаалах давхаргыг хийж өмсөх малгай /ажлын нөхцлөөс хамаарч ямар ч улирлын малгайны дотор өмсөж болно /; 2- хамгаалах давхарга; 3- агааржуулалтын нүх.



5-р зураг. Дулааны улирлын саравчтай малгай. Бүрдэл хэсгүүд:

1- малгайны орой; 2- саравч;



6-р зураг. Хүйтний улирлын чихтэй малгайн гадаад байдал, хэмжих хэсгүүд



7-р зураг. Хүйтний улирлын саравчтай малгайн гадаад байдал, хэмжих хэсгүүд



8-р зураг. Дулааны улирлын малгайн гадаад байдал, хэмжих хэсгүүд

1-р хүснэгт

Бэлэн бүтээгдэхүүний хэмжилтийн хазайлт

Зургийн дугаар	Хэмжилтийн дугаар	Хэмжих хэсгүүд	Хазайлт
3	1	Оройн бүрдэл хэсгийн өндөр	±0,3
3	2	Саравчны өргөн	±0,2
1	3	Өвлийн чихтэй малгайн оройн өндөр	±0,3
1	4	Өвлийн чихтэй малгайн цохны өндөр	±0,2
1	5	Өвлийн чихтэй малгайн чихний өндөр	±0,5
1	6	Өвлийн чихтэй малгайн ар шилний өндөр	±0,2
2	7	Өвлийн саравчтай малгайны чихний урт	±0,5
2	8	Өвлийн саравчтай малгайны шилний урт	±0,5
Малгайн дотор тойргийн урт			±0,5

Тайлбар: Чихтэй малгайны хэмжилтийг дотор цох, чих, ар шилний талаас гүйцэтгэнэ.

А8 ХАВСРАЛТ

Хөл хамгаалах хэрэгсэл







1-р зураг. Хагас түрийтэй ботинкны бүтэц:

1- толгойн өнгө; 2- түрийний өнгө; 3- зулгын өнгө; 4- зөөлөвч; 5- гадуур ул; 6- өсгий; 7- хэлний өнгө; 8- үдээс; 9- бэхэлгээ оёо; 10- гуурс.



2-р зураг. Ботинкны бүтэц.

1- толгойн өнгө; 2- түрийний өнгө; 3- гадар ар сур; 4- зөөлөвч; 5- хэлний өнгө; 6-гуурсан давхаргын өнгө; 7- хамрын хатуулга; 8- хамрын хатуулгын бүрээс; 9- зуузайн хатуулга; 10- толгойн дотор; 11- тусгаарлагч ул; 12- дотуур ул; 13- дэвсгэр улавч; 14-гадуур ул; 15-өсгий; 16- үдээс; 17- гуурс; 18- бэхэлгээ оёо.



3-р зураг 3. Хагас түрийтэй, үдээстэй гутлын бүтэц:
1- толгойн өнгө; 2- түрийний өнгө; 3- зулгын өнгө; 4- зөөлөвч; 5- гадуур ул; 6- өсгий; 7- битүү хэлний өнгө; 8- гадар ар сур; 9- үдээс; 10- гуурс.

а.

1-



5-р зураг. Усны гутлын бүтэц

1- түрийн өнгө; 2- толгойн өнгө; 3- гадуур ул; 4- өсгий.